МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗАР



ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ 2
1.1. Үнэлгээ хийх үндэслэл: 2
1.2. Үнэлгээ хийх хүрээ: 2
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт: 3
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр: 4
1.5. Шалгуур үзүүлэлтийн томьёолол: 6
1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга: 8
ХОЁР. ОЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ 8
2.1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 13
2.2. ОЙН БҮС, ТЭДГЭЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ 15
2.3. ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ 17
2.4. ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ 36
2.5. ОЙГ АШИГЛАХ 43
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 46
Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт 3
Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн харьцуулах хэлбэр 4
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4
Хүснэгт 4. Импортолсон мод, модон материал 7
Хүснэгт 5. Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 7

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 6.2.4-т “Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.3-д “Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон үндсэн ашиглалтын огтлолын бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ”, 3.5.3.4-д “Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ” гэж тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.5.-д “ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийг гаргасан. Мөн Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 5.1-д “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасан.

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зорилго нь хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээл, байгаль орчин, эдийн засагт үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлж, хууль анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч байгаа эсэхийг судалж, цаашид цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох явдал юм.

Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээг хийх бөгөөд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц 1-р бүлэг. Нийтлэг үндэслэл, 2-р бүлэг. Ойн бүс, тэдгээрийн хамгаалалтын дэглэм, 3-р бүлэг. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, 4-р бүлэг. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, 5-р бүлэг. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, 6-р бүлэг. Ойг ашиглах гэсэн бүх бүлгүүдээс агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц зүйл, хэсгүүдийг сонгож үнэлгээний хүрээг тогтоосон.

Ойн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох, уг хуулийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрсэн байдлыг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээ хийж, тохирох хэмжүүрийг сонгон, холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийсэн болно.

Үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дараах алхмуудын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож томьёолох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Үнэлгээний мэдээлэл цуглуулах.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

Үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгож авсан болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт нь хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлт нь хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж үнэлэхэд тохиромжтой юм.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1.	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл.Таримал ойг өмчлөх, ойн санг эзэмшүүлэх 5 дугаар зүйл. Ойн сангийн ангилал, ойн сангийн газар 6 дугаар зүйл. Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам 7 дугаар зүйл. Ойн тооллого, ой зохион байгуулалт, түүний санхүүжилт	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
2.	Хоёрдугаар бүлэг Ойн бүс, тэдгээрийн хамгаалалтын дэглэм	8 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм 9 дүгээр зүйл. Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм 10 дугаар зүйл. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээ	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
3.	Гуравдугаар бүлэг Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх	14 дүгээр зүйл. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүрэн эрх 17 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 18 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх Ойн анги	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.

4.	Дөрөвдүгээр бүлэг Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг	21 дүгээр зүйл. Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг 23 дугаар зүйл. Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
5.	Тавдугаар бүлэг Ойг хамгаалах, нөхөн сэргээх	24 дүгээр зүйл. Ойг хамгаалах арга хэмжээ 27 дугаар дүгээр зүйл. Ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах 28 дугаар зүйл. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хилийн зурвас гаргах, сэргээх 29 дүгээр зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа 30 дугаар зүйл. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх 30^1 дүгээр зүйл. Үржлийн материал бэлтгэх 31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
6.	Зургаадугаар бүлэг Ой ашиглах	32 дугаар зүйл. Бэлтгэж ашиглах модны хэмжээг тогтоох 38 дугаар зүйл. Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаа дээр үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Ойн хуулийн холбогдох зүйлийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо нь хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын тайлан, статистик, судалгааны бүтээл зэрэг болно. Түүнчлэн тус хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтоох бол хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд Ойн тухай хуулиар тогтоосон эрх зүй, зохион байгуулалтын үндэс нь дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны хомсдол, өнөөгийн өөрчлөгдөн буй эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцэж байгаа эсэх, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэн,

хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа эсэх болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн харьцуулах хэлбэр

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1.	Нэгдүгээр бүлэг	4 дүгээр зүйл. Таримал ойг өмчлөх, ойн санг эзэмшүүлэх 5 дугаар зүйл. Ойн сангийн ангилал, ойн сангийн газар 6 дугаар зүйл. Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам 7 дугаар зүйл. Ойн тооллого, ой зохион байгуулалт, түүний санхүүжилт	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа эсэх	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
2.	Хоёрдугаар бүлэг	8 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм 9 дүгээр зүйл. Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм 10 дугаар зүйл. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээ	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа эсэх	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
3	Гуравдугаар бүлэг	14 дүгээр зүйл.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүрэн эрх 17 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 18 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх Ойн анги	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
4.	Дөрөвдүгээр бүлэг	21 дүгээр зүйл.Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг 23 дугаар зүйл. Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
5.	Тавдугаар бүлэг	24 дугаар зүйл. Ойг хамгаалах арга хэмжээ 25 дугаар зүйл. Төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах 26 дугаар зүйл. Ой, хээрийн түймрээс хамгаалах	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших

		27 дугаар зүйл. Ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах 28 дугаар зүйл. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хилийн зурвас гаргах, сэргээх 29 дүгээр зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа 30 дугаар зүйл. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх 30[1] дүгээр зүйл. Үржлийн материал бэлтгэх 31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах		
6.	Зургаадугаар бүлэг	32 дугаар зүйл. Бэлтгэж ашиглах модны хэмжээг тогтоох 38 дугаар зүйл. Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа эсэх	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших

1.5. Шалгуур үзүүлэлтийн томьёолол:

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томьёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд Ойн хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлав.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлтийн томьёолол

№	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1.	4-р зүйл. Таримал ойг өмчлөх, ойн санг эзэмшүүлэх 6-р зүйл. Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам 7-р зүйл. Ойн тооллого, ой зохион байгуулалт, түүний санхүүжилт	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-
2.	8-р зүйл. Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм 9-р зүйл. Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм 10-р зүйл. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээ	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-

3	24-р зүйл. Ойг хамгаалах арга хэмжээ 25-р зүйл. Төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах 26-р зүйл. Ой, хээрийн түймрээс хамгаалах 27 -р зүйл. Ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах 28-р зүйл. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хилийн зурвас гаргах, сэргээх 29-р зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа 30-р зүйл. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх 30^1-р зүйл. Үржлийн материал бэлтгэх 31-р зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-
4	21 дүгээр зүйл. Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг 23 дугаар зүйл. Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-
5	24 дугаар зүйл. Ойг хамгаалах арга хэмжээ 25 дугаар зүйл. Төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах 26 дугаар зүйл. Ой, хээрийн түймрээс хамгаалах 27 дугаар зүйл. Ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах 28 дугаар зүйл. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хилийн зурвас гаргах, сэргээх 29 дүгээр зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа 30 дугаар зүйл. Ойг нөхөн сэргээх, үржүүлэх 30^1 дүгээр зүйл. Үржлийн материал бэлтгэх 31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-
6	32 дугаар зүйл. Бэлтгэж ашиглах модны хэмжээг тогтоох	Зорилгод хүрсэн байдал ба	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	-

	38 дугаар зүйл. Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим	хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал		

1.5. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга:

Үр дагаврын үнэлгээний мэдээллийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, "TA-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр" төслийн тайлан, Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн баталсан Монгол орны ойн сангийн төлөв байдлын шинэчилсэн мэдээлэл 2021 он, Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2021 зэрэг эх сурвалж, холбогдох судалгаа, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ.

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны тайлан, статистик тоо баримт, хуулийн үзэл баримтлал зэрэг эх сурвалжийг ашигласан.
- **Холбогдох субъектүүдтэй уулзаж, мэдээлэл авах:** Хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй, бодитой гаргах, уг хуулийн харилцаанд оролцогч субъектүүдээс эрх тэгш мэдээлэл авах зорилгоор БОАЖЯ, Ойн газар, Ойн салбарын мэргэжлийн холбоод зэрэг байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийх, бүлгийн ярилцлага зохион байгуулах зэргээр мэдээлэл цуглуулахаас гадна бусад мэдээллийг цуглуулсан.

ХОЁР. ОЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Ойн тухай хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Хуулийн хэрэгжилтийн хангуулах чиглэлээр холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан дараах журам, заавар, аргачлал батлахаар тогтоосон. Үүнд:

1. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журам- Засгийн газар батална;
2. Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журам- Засгийн газар батална;
3. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам болон бусад журам, шийдвэр- Засгийн газар батална;
4. Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах журам- Засгийн газар батална;
5. Мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
6. Ойн экологи, эдийн засгийн үнэлгээг батлах- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
7. Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулах журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
8. Эзэмшлийн ойд эзэмшигчээс бусад этгээд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах тохиолдолд тухайн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардлын тодорхой хувийг ойн санг гэрээгээр эзэмшигчид төлөх журам- Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална;
9. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг зохицуулах журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
10. Ойн аж ахуйн арга хэмжээний заавар, аргачлал- Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална;

11. Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам- Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална;
12. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;
13. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам- Санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална;
14. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журам- Санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална;
15. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална;
16. Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журам-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарч батална;
17. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу төрөөс худалдан авах буюу бусад хэлбэрээр урамшуулах олгох журам- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарч батална;
18. Ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журам- Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангаас шүүлт хийж үзэхэд:

1. Ойн тухай хуулийн дагуу Засгийн газрын баталсан журам, шийдвэр:

Хуулийн зүйл, хэсэг, заалт	**Журам, шийдвэрийн нэр**	**Шийдвэр**	
		Он, сар, өдөр	**Дугаар**
1. Засгийн газрын шийдвэр			
Ойн тухай хуулийн 4.9 дэх хэсэг	Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж болох хамгаалалтын бүсэд хамаарах ойн сангийн нэршлийн жагсаалт	2013.6.15	Засгийн газрын 213 дугаар тогтоол
Ойн тухай хуулийн 12.1.5 дахь заалт	Ойн нөөц, төлөв байдал, ашиглалтын эрчимжилтээс хамааруулан ойн ангийн хариуцах талбайн, норматив, байршлыг батлах	2012.07.25	Засгийн газрын 255 дугаар тогтоол
Засгийн газрын тухай хуулийн 30.1 дэх хэсэг	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2021.11.17	Засгийн газрын 350 дугаар тогтоол
2. Засгийн газрын баталсан журам			

Ойн тухай хуулийн 4.10 дахь хэсэг	Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журам	2009.07.22	Засгийн газрын 277 дугаар тогтоол
Ойн тухай хуулийн 7.5 дахь хэсэг	Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх тухай журам	2013.3.22	Засгийн газрын 105 дугаар тогтоол
Ойн тухай хуулийн 12.1.6 дахь заалт	Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам болон бусад журам, шийдвэр	2013.03.22	Засгийн газрын 106 дугаар тогтоол
Ойн тухай хуулийн 39.1 дэх хэсэг	Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах журам	2009.07.22	Засгийн газрын 227 дугаар тогтоол

2. Ойн тухай хуулийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан журам, шийдвэр:

Хуулийн зүйл, хэсэг, заалт	**Журам, шийдвэрийн нэр**	**Шийдвэр**		**ХЗДХЯ**	
		Он, сар, өдөр	**Дугаар**	**Бүртгэлийн дугаар он сар өдөр**	**Хянуулааг үй эсвэл хүчингүй болсон**
1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны гаргасан шийдвэр					
Ойн тухай хуулийн 13.1.13 дахь заалт	Ойн экологи, эдийн засгийн үнэлгээг батлах	2020.03.16	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/176 дугаар тушаал	2020-03-30-ны 4744	
Ойн тухай хуулийн 23.3 дахь хэсэг	Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам	2023.09.01	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/428 дугаар тушаал	2023.09.18-ны	
Ойн тухай хуулийн 6.2 дахь хэсэг	Мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам	2013.02.19	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-53 дугаар тушаал		-
2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны баталсан журам					
Ойн тухай хуулийн 10.2 дахь хэсэг	Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга	2013.05.01	Засгийн газрын А-134 дүгээр тогтоол	2013-05-20-ны өдрийн 3379	

	хэмжээ явуулах журам				
Ойн тухай хуулийн 28.5 дахь хэсэг	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам	2020.12.15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/654 дүгээр тушаал	2020-12-28-ны 4932	
Ойн тухай хуулийн 34.5 дахь хэсэг	Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам	2013.05.15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-153 дүгээр тушаал	2013.08.26-ны 3397	
Ойн тухай хуулийн 35.5 дахь хэсэг	Ойгоос мод бэлтгэх журам	2016.12.13	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/133 дугаар тушаал	2017.01.03-ны 3681	
Ойн тухай хуулийн 38.6 дахь хэсэг	Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулах журам	2023.09.13	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/450 дугаар тушаал	2014.05.29-ний 3448	
Ойн тухай хуулийн 4.13 дахь хэсэг	Эзэмшлийн ойд эзэмшигчээс бусад этгээд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах тохиолдолд тухайн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардлын тодорхой хувийг ойн санг гэрээгээр эзэмшигчид төлөх журам	-	-	-	-
Ойн тухай хуулийн 13.1.24 дахь заалт	Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар технологи, норм, нормативын үндэслэл боловсруулах, батлах	-	-	-	-
Ойн тухай хуулийн 13.1.27 дахь заалт	Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын явуулах үйл ажиллагааны	2009	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 70 дугаар тушаал		-

	хөтөлбөр, ойн ангийн эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл, ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам				
3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтран баталсан журам					
Ойн тухай хуулийн 30.1 дахь хэсэг	Ойжуулалт, ойн аж ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам	2009/ 2013	Сангийн сайд болон Байгаль орчны сайдын 2009 оны 139/154 тоот хамтарсан тушаалаар баталсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын 2013 оны 368/302 тоот тушаалаар хүчингүй болсон.		-
Ойн тухай хуулийн 39.2, 39.3, 39.5 дахь хэсэг	Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдэд урамшуулал олгох журам	2020. 02.11	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарсан 33/А/63 дугаар тушаал	2020-02-28-ны 4726	
Ойн хууль 39.4, 39.10, 39.5 дахь хэсэг	Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу төрөөс худалдан авах буюу бусад хэлбэрээр урамшуулах олгох журам	2015. 03.31	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарсан А-140/63 дугаар тушаал		-

Ойн тухай хуулийн дагуу батлах шаардлагатай зарим журам, заавар, аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлээгүй, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлээгүй тул хүчин төгөлдөр бус байна.

Ойн тухай батлагдсанаас хойш өнгөрсөн хугацаанд буюу 2012-2023 онуудад нийт 12 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна.

2.1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Үнэлэх хэсэг	**4 дүгээр зүйл.Таримал ойг өмчлөх, ойн санг эзэмшүүлэх** 4.2. Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно. 4.10. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална. 4.13. Энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно. /ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардал/ **6 дугаар зүйл. Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам** 6.1. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна. 6.2. Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **30 дугаар зүйл.Ойг нөхөн сэргээх, үржүүлэх** 30.5. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж байгаа эсэх? - Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар баталсан эсэх? - Ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага баталсан эсэх? - Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээний ойн мэдээллийн сан байгуулсан эсэх, холбогдох журам баталсан эсэх?

- *<u>Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж байгаа эсэх?</u>*

Ойн тухай хуулийн 4.2-т Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно гэж заасан боловч өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд ой модыг өмчилсөн тохиолдолд байхгүй байна.

Энэ нь хэд хэдэн шалтгаантай байна. Тодруулбал, “таримал ой”-н тухай тодорхойлолт Ойн тухай хуульд тодорхой тусгагдаагүй, “ой”-оос юугаараа ялгаатай болох нь тодорхой биш байна. Мөн таримал ойн доорх газрын харилцааг Ойн тухай хууль, Газрын

тухай хууль тогтоомжуудад зохицуулаагүй байгаа тул хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал үүссэн байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 1-т Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна, мөн зүйлийн 2-т Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гэж тус тус заасан тул ойг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх тухай зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиудтай зөрчилтэй байна. Өөрөөр хэлбэл энэхүү зохицуулалт практикт хэрэгжих боломжгүй байна.

- *Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар баталсан эсэх?*

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 227 дугаар тогтоолоор “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг баталсан байна.

- Эзэмшлийн ойд эзэмшигчээс бусад этгээд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах тохиолдолд тухайн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага баталсан эсэх?

Ойн тухай хуулийн 4.13-т Энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно /ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардал/ гэж заасан боловч энэ журам одоогоор батлагдаагүй байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай хэрхэн уялдах нь тодорхойгүй байгаатай холбоотой байна. БНАТТХ-ийн 1-р зүйлд тус хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна гэж заасан. Тус хуулийн 18.1-т зааснаар ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна гэж заасан тул хууль хоорондын уялдаа тодорхойгүй, давхардсан байдал үүсжээ.

- *Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээний ойн мэдээллийн сан байгуулсан эсэх, холбогдох журам батлагдсан эсэх?*

Ойн тухай хуулийн 6.1-т Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна гэж заажээ. Ойн тухай хуулийн 6.1-т заасан ойн мэдээллийн санг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р бүлэгт заасан Байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл хэсэг болж байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн эрхлэн хөтөлж байна.

Ойн тухай хуулийн 6.2-т Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заажээ. Энд заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 02 сарын 19-ны өдрийн А-53 тоот тушаалаар “Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх тухай журам”-ыг баталсан байна. Гэвч тус журмын 2.4-т “мэдээллийн сангийн мэдээ бүрдүүлэх, боловсруулах, түгээх программ хангамжийг хөгжүүлэх, ажиллах горимыг зохицуулах, шуурхай байдал, хамгаалалт, нууцлалтын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг Байгаль орчны мэдээллийн

төв хариуцан ажиллана” гэж, 2.5-т “Мэдээллийн сангийн мэдээг бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, ашиглах, түгээх, хадгалах, баяжуулах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал, зөвлөмж гаргах, хэрэглэгчдэд нээлттэй болон төлбөртэй мэдээллийн жагсаалт гаргах, мэдээллийн үнэн зөв байдал, чанар, анхдагч боловсруулалтыг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хариуцна тус тус заасан. Засгийн газрын 2022 оны 7-р сарын 5-ны өдрийн 272-р тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газрыг байгуулахаар шийдвэрлэсэн боловч шинээр байгуулагдсан Ойн газар ойн мэдээллийн сан бүрдүүлэхэд ямар чиг үүрэгтэй оролцох нь тодорхойгүй байсаар байна.

“Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх тухай журам”-ын дагуу ойн анги нь мэдээллийн сангийн бүртгэл, тайланг хариуцан гүйцэтгэнэ гэж заасан боловч зарим ойн анги мэдээллийн сангийн талаарх мэдээлэл дутмаг, хэрэгжүүлэлт хангалтгүй байна.

2.2. ОЙН БҮС, ТЭДГЭЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

Үнэлэх хэсэг	**8 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм** 8.1.Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна. 8.2.Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна. 8.3.Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно. 8.4.Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна. 8.5.Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах зорилгоор нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах ойн заагийг дор дурдсанаар тогтооно: 8.5.1.нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар; 8.5.2.нийслэлээс бусад хотын 30 хүртэл километрийн доторх ногоон бүсэд хамаарах ойн заагийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага; 8.5.3.төв, суурин газрын ногоон бүсэд хамаарах ойн заагийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал. 8.6.Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. **9 дүгээр зүйл.Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм** 9.1.Энэ хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад ой ашиглалтын бүсийн ойд хамаарна. 9.2.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын бүсийн ойгоос мод, ойн дагалт баялгийг зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглах эрхтэй. 9.3.Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Хамгаалалтын бүсийн ойн заагийг холбогдох төрийн байгууллагууд тогтоосон эсэх? - Хамгаалалтын бүсийн ойн дэглэмийн хэрэгжилтийн байдал?

- *<u>Хамгаалалтын бүсийн ойн заагийг холбогдох төрийн байгууллагууд тогтоосон эсэх?</u>*

Ойн тухай хуулийн 8.1-д зааснаар хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна гэж, 8.3-т цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно гэж, 8.5.1-д нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар тус тус тогтооно гэж заасан.

2021 оны байдлаар Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл аймгууд цармын бүслүүрийн ойн заагийг тогтоосон байгаа бөгөөд нийт 39,136 га талбай үүнд хамаарч байна.[1] Нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газрын 1996 оны 326-р тогтоолын хавсралтаар тогтоосон байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн ногоон бүсийн ойд 887,538 га газар[2] хамаарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан. Улсын хэмжээнд 107 ТХГ[3] байгаа бөгөөд улсын тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ 21927.0 мянган гад хүрчээ. Нийт дүнгээр авч үзвэл хамгаалалтын бүсийн ойд 7,611,537 га газар хамаарч байгаа бөгөөд энэ нь нийт ойн сангийн 83,1 хувийг хамаарч байна.

- *<u>Хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойн дэглэмийн хэрэгжилтийн байдал, нийтлэг зөрчлүүд?</u>*

Ойн тухай хуулийн 8.6-д хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно, 9.2-т Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын бүсийн ойгоос мод, ойн дагалт баялгийг зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглах эрхтэй гэж тус тус заасан.

Тусгай хамгаалалттай газрын хувьд тусгайлсан хуультай, тухайн хуулиар нь хамгаалалтын газрын захиргаа байгуулагдаж, чиг үүрэг нь тодорхой тусгагдсан тул хамгаалалтын дэглэм тодорхой хэмжээнд хэрэгжиж байна. Харин бусад хамгаалалтын бүсийн ойд хамгаалалтын дэглэм хангалтгүй хэрэгжиж байна. Учир нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмагаас гадна хамгаалалтын бүсийн ойг хариуцах этгээд тодорхой биш, байгаль хамгаалагчийн хүрэлцээ, техник, хангамж муу байгаатай холбоотой байна.

Байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд “Ойн тухай” хууль зөрчсөн зөрчил 2004 онд 36.8 хувийг эзэлж байсан бол 2022 онд 10 хувь болж буурсан байна. Ойтой холбоотой бүртгэгдсэн хэрэг, зөрчил 2011 онд 1246 байсан бол 2021 онд 460 болон буурсан байна.[4] Ойн тухай хуулийн зөрчлийг бүтцээр ангилж авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

[1] Монгол Улсын ойн сан, 14-р хавсралт, Ойн судалгаа, хөгжлийн төв, 2021 он
[2] Монгол Улсын ойн сан, 14-р хавсралт, Ойн судалгаа, хөгжлийн төв, 2021 он
[3] https://www.eic.mn/spa/
[4] Ойн тухай хуулийн зөрчил, анхаарах асуудал сэдэвт танилцуулга, МХЕГ, 2022.04.15



Судалгаанаас үзэхэд зөрчил гарахад голлон нөлөөлж байгаа хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлсон.

- Огтлолтын төрөл өөрчлөх, гэрээ, эрхийн бичгийн нөхцөл зөрчих, ой зохион байгуулалтын тайлан, мэдээ зөрөх,
- Гарал үүслийн гэрчилгээг дахин ашиглахыг оролдох
- Мод боловсруулах тоног төхөөрөмжийн талаарх эрхзүйн зохицуулалт байхгүй, дутмаг
- Хяналтын нэгдсэн систем хөгжөөгүй, байгаль хамгаалагчдын хүрэлцээ бага,
- Ойн ангийн боловсон хүчний чадавх хангалтгүй.

- *<u>Ойн хамгаалалтын дэглэмийн үр дагавар?</u>*

Монгол Улс өнгөрсөн хугацаанд ойг хамгаалах бодлогыг түлхүү хэрэгжүүлж ирсэн байна. Энэхүү бодлогын хүрээнд ойн нөөц ашиглалтыг жил бүр ойгоос бэлтгэх модны квот тогтоох, ойн нөхөрлөлд зөвхөн унасан мод түүх, огтлох, ойн сангийн тодорхой хэсгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт тооцож ой мод огтлохыг хязгаарлах замаар хэрэгжүүлжээ. Өнөөдрийн байдлаар ойн сангийн 15471.5 мян.га буюу 83.1% нь хамгаалалтын бүсийн, 3136.5 мян.га буюу 16.9% нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна. Ойг хамгаалах бодлогыг дангаар нь хэрэгжүүлснээр ой сангийн нөөцийн 76 хувь нь болц гүйцсэн буюу хөгширсөн, унанги болон ойн хөнөөлт шавжид идэгдсэн ойн талбай ихээр нэмэгдсэнээр ойн цэвэрлэгээний зардал үлэмж нэмэгдсэн, залуу мод ургах буюу ойн байгалийн нөхөн сэргээлт явагдах нөхцөл багассан, ойн эдийн засгийн бүтээмж буурсан, ойг эдийн засгийн эргэлтэд оруулахыг хязгаарласнаас ойн анги, ойн мэргэжлийн байгууллагууд бие даагаагүй, зөвхөн төсвийн хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай болсон зэрэг сөрөг үр дагаврууд үүссэн байна.

2.3. ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

Үнэлэх хэсэг	**14 дүгээр зүйл.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүрэн эрх** 14.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/, аймаг, нийслэлийн байгаль орчны газрын бүрэлдэхүүнд ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, аймаг, суманд сум дундын болон сумын ойн анги /цаашид "ойн анги" гэх/ ажиллана.

	17.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.1.1.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих; 17.1.6.ойн талбайн хэмжээний нормативыг харгалзан нутаг дэвсгэртээ байх ойн ангийн жагсаалт, тухайн жилийн төсвийг батлах. 17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.8.аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоог батлан, тэдгээрийн даргыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх; 18.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.1.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг батлах, биелэлтэд хяналт тавих; 18.1.7.шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах; 18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.2.9.ойн ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтныг томилох, чөлөөлөх;
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо нь ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тохирч байгаа эсэх? - Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавх нь хуулиар олгосон чиг үүргээ хангалттай түвшинд хэрэгжүүлэх хэмжээнд хүрсэн эсэх? - Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны газрын ойн асуудал хариуцсан нэгж, ажилтан, ойн ангийн чиг үүрэг уялдаж байгаа эсэх? - Сум дундын болон сумын ойн анги нь аймаг, сумын Засаг даргын эрхлэх асуудалд харьяалагдаж буй нь оновчтой эсэх?

- *<u>Хуульд заасан ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо нь ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх чадавхтай, үр нөлөө бүхий бүтцийг бий болгосон уу?</u>*

Хуулийн дээрх зохицуулалтаас үзвэл ойн салбар дахь төрийн удирдлагын тогтолцоо нь хөндлөн бүтэцтэй. Тодруулбал, бодлогын түвшинд төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажилладаг. Эдгээр нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн хээрийг түймрээс хамгаалах, байгаль орчны тэнцлийг хангах талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх холбогдох дүрэм, журам, стандартыг батлах, биелэлтийг хангуулах, ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг улсын хэмжээнд ойн салбарын удирдлага, зохион байгуулалт, төрийн бодлого, хууль тогтоомжийг хангуулах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлдэг. Гүйцэтгэлийн түвшний буюу эдгээр төрийн бодлого, хууль тогтоомжийг практикт хэрэгжүүлэх чиг үүрэг нь аймаг, нийслэлийн БОАЖГ болон ойн ангиудад харьяалагддаг. Бодлогын түвшний байгууллагууд нь босоо буюу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд байдаг бол гүйцэтгэлийн түвшний байгууллагууд нь орон нутагт харьяалагддаг. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.2.8, 18 дугаар зүйлийн 18.2.9-д тус тус зааснаар сум дундын болон сумын ойн ангийг төсвийг тухайн шатны ИТХ баталж, даргыг нь мөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлдөг. Ойн салбарын удирдлагын энэхүү зохион байгуулалтыг төвлөрлийг ихээхэн

сааруулж, ойн ашиглалттай холбоотой шийдвэрийг хэд хэдэн шийдвэр гаргах байгууллагуудад тараасан гэж олон улсын судалгааны тайланд дурджээ.[5]

Ойн салбарын удирдлагын тогтолцооны энэхүү нөхцөл байдлаас улбаалж, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн ойг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажилд үр дүнгүй болоход хүргэхүйц дараах асуудал тулгамдаж байна.

Нэгд, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа холбооны хувьд хангалтгүй байна. Аймгийн түвшинд байгаль орчин, аялал жуулчлалын газарт цөөн тооны ойн хэлтэс, газар, мэргэжилтэн ажилладаг. Сум орон нутгийн түвшинд ойн ангиуд нь ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагыг хариуцан ажилладаг. Энэ дагуу ойн асуудлаар гарсан бодлогын шийдвэр, арга хэмжээг эхлээд орон нутагт Засаг дарга, дараа нь түүний харьяа байгаль орчин, аялал жуулчлалын газарт, эцэст нь ойн ангийн дарга нарт хүргүүлсний эцэст хэрэгждэг нь цаг хугацаа, шат дамжлага ихтэй процесс байна.

Хоёрт, ойн салбарын улс төрийн хамаарлыг багасгах шаардлага тулгарсан байна. Аймаг, сумын Засаг дарга нь төрийн улс төрийн албан тушаалтан бөгөөд дөрвөн жил тутам болдог улс төрийн сонгуулийн үр дүнгээр томилогддог. Ойн салбарын бодлогыг хээрийн түвшинд гардан хэрэгжүүлж буй ойн ангийн удирдлагыг дээрх хуулийн зохицуулалтад зааснаар улс төрийн албан тушаалтан томилж, чөлөөлөх, ажлыг нь үнэлж дүгнэх эрх хэмжээтэй байгаа нь ойн салбарын тогтвортой менежмент анхан шатанд хэрэгжихэд хүндрэл учруулж байж болзошгүй юм. Тодруулбал, улс төрийн сонгуулиас хойш дөрвөн жилийн дотор сум дундын ойн ангийн дарга нар тогтмол солигдож байгаа нь судалгааны явцад хийгдсэн үнэлгээ, хэлэлцүүлгийн дүнгээс ажиглагдаж байна.[6] Тус судалгааны явцад 36 ойн ангийн дарга, инженер зэрэг 43 албан хаагчтай ярилцлага хийсэн бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ямар нэг саад бэрхшээл тулгардаг эсэхийг асуухад ихэнх нь улс төрийн намын сонгуулийн дөрвөн жил тутамд төрийн албанд тодорхой хэмжээний халаа сэлгээ хийдэг байдал нь гол саад бэрхшээл учруулдаг гэж мэдэгдсэн байна. Тодруулбал, сум дундын ойн ангийн даргыг мэргэжлийн бус хүмүүсээр байнга сольж хольж байдаг бөгөөд ойн инженерүүд ажлаа эхнээс нь даргадаа тайлбарлаж богино хугацаанд ажлаа ойлгуулж явуулах процесс нь ихээхэн хүндрэл учруулдаг. Түүнчлэн дарга солигдсоны дараа ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа дуусаагүй байсан ч төлөвлөсөн ажил өөрчлөгдөх байдал ажиглагддаг байна. Түүнчлэн ойн анги, ойн байгууллагуудын дарга нар эсхүл орон нутгийн засаг захиргааны дарамт, хууль бус үйлдлийг таслан зогсоох гэхэд сум дундын ойн ангийн албан хаагчдын эрх хэмжээ дутмаг байх явдал, орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлэхгүй байх явдал, ажлын байрны тогтворгүй байдал зэрэг нь тулгамдсан асуудал болдог талаар дурджээ.[7]

Гуравт, ойн салбарын удирдлагын нэгдмэл байдал бүрдэж чадаагүй байгаа нь хээрийн түвшинд ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэгч гол субъект болсон ойн ангиудын чадавх суларч, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, төсөв санхүүгийн хувьд чадавхжиж чадахгүй байгаа нь ойн салбарын хөгжилд саад болж буй нэг хүчин зүйл болжээ. Зөвхөн санхүүгийнӣн чадавхын тулгамдсан асуудлыг авч үзвэл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн төслийг ойн ангиас орон нутгийн Засаг дарга, дараа нь Ойн хэлтэс, дараа нь аймгийн Засаг дарга, дараа нь яаманд шилжиж ирсэн үед төсөв боловсруулдаг. Сангийн яам ихэвчлэн төсвийн саналын талыг нь хасдаг ба эцэст нь маш их танаж, хассан төсвийн үлдэгдэл ойн ангид ирдэг. Ихэнх тохиолдолд энэ нь 6 орон тооны зөвхөн 3 орон тоог нь цалинжуулах боломжтой төсөв батлагддаг бөгөөд үлдсэнийг нь ойн анги өөрсдийн орлого, орон нутгийн засаг захиргаа эсвэл зарим тохиолдолд орон нутгийн компани эсхүл төслөөс тодорхой хэмжээний санхүүжилт авч

[5] TA9899 Interim Report, para 234.

[6] Финляндын Зөвлөх групп, Монголын Ойн судалгааны нийгэмлэг ТББ, TA-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ (Хавсралт 6) (2022). 9 дэх тал

[7] Мөн тэнд.

аргацаасан байдлаар цалинжуулж байна.[8] (Сум, сум дундын ойн ангитай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар энэ тайлангийн холбогдох бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.)

Ойн аж ахуй нь урт хугацааны хэтийн төлөв, зохион байгуулалтыг шаарддаг салбар бөгөөд ингэснээр ирээдүйд салбар урт хугацаандаа илүү тогтвортой хөгжих үндэс болдог. Сүүлийн хэдэн арван жилд ойд хөрөнгө оруулалт их хийгээгүйн улмаас ойн нөхцөл байдал улам бүр муудсаар байна. (Энэ талаар ойг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийсэн хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.)

Хөрөнгө оруулалт хийх хөрөнгө мөнгө байхгүй байгаа нь одоогийн бүтэц, зохион байгуулалт зөв ажиллаж чадахгүй байгааг харуулж байна. Ой ургах орчин нөхцлийг сайжруулах, ойжуулсан талбайг хамгаалах, арчилгаа цэвэрлэгээ болон нөхөн сэргээсэн талбайд мод бэлтгэл явуулах үлгэрчилсэн талбайн загвар бий болгох, дэд бүтцийг сайжруулах, ойн түймэр, хортон шавжийн хор хөнөөл, аюулыг бууруулахын тулд ойн менежментийг хэрэгжүүлэхэд эргээд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Ийм хэмжээний санхүүжилтийн тогтолцоог бий болгож ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх үндэс суурь нь тогтвортой, бат бэх, үр нөлөөтэй, чадавхтай, шуурхай ажилладаг удирдлагын тогтолцоог бүрдүүлэх явдал мөн.

Ойн аж ахуйн асуудлыг хариуцах босоо бүтэцтэй, чадавхитай захиргаатай болох шаардлагатай байна. Ойн газрыг шинээр байгуулсан байгуулснаар ойн салбарын байгууллагын зохион байгуулалтын үйл явц босоо бүтэцтэй болоход нэг алхам ойртсон боловч ойн салбарын бодлогын арга хэмжээг практикт буюу хээрийн түвшинд хэрэгжүүлэх бүтэц байхгүй хэвээр байна. Иймд хууль тогтоомж, БОАЖЯ, Ойн газрын шийдвэрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ойн ангиудын удирдлагыг орон нутгийн харьяаллаас гаргаж, босоо бүтэцтэй болгох шаардлагатай. Үүний үр дүн нь байгууллагын зохион байгуулалт босоо бүтэцтэй болох төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд орон нутгийн түвшинд улс төрийн нөлөөллөөс шалтгаалсан шийдвэрээс ангид болох, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн мэдлэгт тулгуурласан шийдвэр гаргах, ойн салбарын санхүүжилтийн тогтвортой байдал бүрдэх боломжтой болно.

Дээр дурдсан судалгаанд оролцсон ойн ангийн зүгээс ч эдгээр саад бэрхшээлийг бууруулахын тулд юуны өмнө босоо удирдлагатай болж ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад харьяалагдах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.[9]

<u>Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд, ялангуяа сум, орон нутгийн түвшинд ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хуваарилан санхүүжүүлж чаддаг уу?</u>

Хуулийн зохицуулалт ёсоор ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ жил бүр батлахаар заасан боловч ойтой холбоотой үйл ажиллагааны өнөөгийн санхүүгийн менежмент нь ойд үр өгөөж өгөхгүй байна.

Цаашлаад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (БНАТ хууль) нь ойн салбарын хувьд шударга бус, учир нь ойн менежментийг хэрэгжүүлэх үүрэг нь сум дундын ойн ангид үлддэг ч ойн ашиглалтын эрх болон бусад хураамжаас хуримтлагдсан бүх орлого нь орон нутгийн төсөв ордог. БНАТ-ийн тухай хуульд заасны дагуу мод бэлтгэхэд цуглуулсан төлбөрийн орлогын 85 хувиас тодорхой хувийг ойн менежментийг хариуцдаг байгууллагад (ойн анги) буцааж өгөх нь зүйтэй юм.

Ярилцлагад хамрагдсан бараг бүх ойн ангиуд ойд чиглэсэн дахин хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд зориулан ямар нэгэн санхүүжилтийн эх үүсвэр орон нутгийн төсвөөс

---

[8] Мөн тэнд

[9] Финляндын Зөвлөх групп, Монголын Ойн судалгааны нийгэмлэг ТББ, TA-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ (Хавсралт 6) (2022), 9 дэх тал.

буцааж аваагүй нь судалгаагаар харагдсан. Судалгаанд оролцогчдын цөөнх нь л ажилчдын цалингийн талаар бага зэргийн дэмжлэг авсан гэж хариулсан. Энэ төрлийн санхүүгийн бодлого нь ойн менежментийн хөгжилд саад болж байна.

2.4.ИРГЭН, ОЙН НӨХӨРЛӨЛ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

Үнэлэх хэсэг	**21 дүгээр зүйл.Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг** 21.1.Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна. 21.3.Ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина. 21.4.Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 21.12.Энэ хуулийн 21.9-д заасны дагуу гэрээ байгуулсан ойн нөхөрлөл дараах эрхийг эдэлнэ: 21.12.1.эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах;
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойн нөхөрлөлүүд нь хуульд заасны дагуу ойн менежментийн төлөвлөгөө гаргасан уу? Ямар субъект боловсруулж баталдаг вэ? - Ойн нөхөрлөлүүд нь жил бүр үйл ажиллагааны тайлангаа сум, дүүргийн ИТХ-д танилцуулдаг уу? - Ойн нөхөрлөлүүд нь өөрийн эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсэгт ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулдаг уу? - Ойн нөхөрлөлүүд нь эзэмшлийн ойдоо ойн менежментийн төлөвлөгөөний дагуу зохих үйл ажиллагааг явуулж байна уу? - Ойн нөхөрлөл нь хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бүрдсэн үү? Сум орон нутгаас дэмжлэг үзүүлдэг эсэх.

Монгол Улсад байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийг татан оролцуулах, хамтын менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлэх зохион байгуулалтын нэг хэлбэр нь иргэдийн нөхөрлөл юм. Ойн нөхөрлөлийн хувьд энэхүү зорилгыг нэгэн адил хэрэгжүүлж, ойн нөөцийн тогтвортой менежмент, ашиглалтыг хангах, доройтсон ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг субъект юм.

<u>Ойн нөхөрлөлүүд нь хуульд заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байгаа юу?</u>

Ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг сум, дүүргийн ИТХ-аас гарсан шийдвэрийн дагуу Засаг даргатай гэрээ байгуулж эзэмшинэ. Нөхөрлөл нь тухайн газар нутагтаа үеийн үедээ амьдарч байгалийн баялгаа зүй зохистой ашиглаж, хамгаалж ирсэн нутгийн иргэд нөхөрлөл болон зохион байгуулалтад орсноор ойн цэвэрлэгээ, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн түймэр, хортноос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, нуур цөөрмийн усны ундаргыг хамгаалах, хөв, цөв байгуулах, аргаль хонь, янгир ямаа, соргог бөхөн, цоохор ирвэс, халиун буга, хар сүүлтэй зээр, тарвага зэрэг нэн ховор, ховордсон амьтдын тоо толгой нэмэгдэх, хууль бус ан агналтыг таслан зогсоох, биотехникийн арга хэмжээ авах, байгалийн ургамлыг тарьж ургуулах, бэлчээрийн зохистой ашиглах зэрэг өргөн цар хүрээтэй ажлыг гүйцэтгэдэг болж байна.

Эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу тасралтгүй үйл ажиллагаа явуулах, хуульд заасан журмын дагуу ойн нөөц, дагалт баялгийг ашиглах, худалдан борлуулах зэрэг үйл ажиллагааг явуулна. Товч дүгнэж үзвэл, ойн нөхөрлөл нь байгаль орчны тухай хууль тогтоомжид заасны дагуу байгуулагдсан бусад нөхөрлөлийн адилаар зөвхөн байгалийн тодорхой баялгийг "хариуцан хамгаалах" зорилгоор ашиглаж эзэмшдэг өвөрмөц субъект бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй юм.

Дээрх онцлог зохицуулалтаас үзвэл ойн нөхөрлөлийн эрх, үүрэг, зохион байгуулалт, сум орон нутаг болон төрөөс үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагааны суурь зохицуулалтыг дахин авч үзэх шаардлага үүсгэж байгаа юм. Ойн тухай хуулийн дээрх заалтад зааснаар ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд хуулиар тодорхойлж өгсөн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх суурь нь энэхүү төлөвлөгөө юм.

Ойн ангийн чадавхын үнэлгээний тайланд дурдсанаар Монгол Улсын хэмжээнд ойролцоогоор 1,267 ойн нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулж байна.[10] Үүнд зөвхөн Ойн тухай хуульд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангасан ойн нөхөрлөлүүдээс гадна гэрээний хугацаа, гэрчилгээ нь дуусан нөхөрлөлүүд ч мөн багтсан. Эдгээр нөхөрлөлүүд дунджаар 20 гишүүнтэй бөгөөд нийт 4143 га ойн сангийн талбайг гэрээгээр эзэмшиж байна. Дээр дурдсан судалгааны хүрээнд нийт 107 нөхөрлөлөөс нэг бүрчлэн чадавхын үнэлгээ авч судалсан.

Эдгээр нөхөрлөлийн 86 хувьд ойн менежментийн төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүний 92 хувь нь сумын ИТХ-аар батлуулжээ. Эдгээрээс ойн менежментийн төлөвлөгөөг ойн мэргэжлийн байгууллагаар 58, ойн ангиар 31 хийлгэсэн бол бусад нь өөр байгууллагаар хийлгэсэн бөгөөд ийнхүү мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь төсөв санхүүгийн хувьд зардалтайгаас гадна өөрсдийн үйл ажиллагаанд нь төдийлөн хэрэг болдоггүй, газар дээр нь ирж боловсруулалт хийдэггүй, бусдын төлөвлөгөөг хуулсан байхаас гадна ойн нөхөрлөлүүд мод бэлтгэх эрхгүй байхад нь бодит байдал дээр огт хэрэгжихээргүй ой зохион байгуулалтын тайлангаас хуулсан тоонууд гаргасан байдаг аж.[11]

Уг зүй нь ойн нөхөрлөл бол ойг хариуцан хамгаалах зорилготой, мэргэжлийн бус буюу иргэд, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн сайн дурын шинжтэй байгууллага юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ОТХ-иар ойн менежментийн төлөвлөгөөтэй байхаар заасан нь тухайн хариуцаж буй ойн талбайд хэрэгжих мэргэжлийн шинжтэй үйл ажиллагааг ойн нөхөрлөлүүд хийх мэт давхардсан ойлголтыг бий болгожээ. Энэ үүднээс ойн менежментийн төлөвлөгөөг эргэн авч үзэж зөвхөн тухайн сумын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх талууд анхаарч ажиллах боломжийг бүрдүүлэхийг анхаарах нь зүйтэй байна.

<u>Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавьдаг уу?</u>

Хуульд ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх талаарх цорын ганц зохицуулалт нь сум, дүүргийн ИТХ-д жил бүр ажлаа тайлагнах тухай 21.3 дэх хэсэг юм. Засаг даргын хувьд зөвхөн хуулийн 21.11-д заасан тохиолдолд тухайн ойн санд нөхөрлөлийн явуулах үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална. Иймд ойн нөөцийн тогтвортой менежмент, ашиглалтыг хангах, доройтсон ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажилд чухал үүргээ ойн нөхөрлөл хэр зэрэг хэрэгжүүлж буйг үнэлж дүгнэх гол механизм нь энэхүү зохицуулалт учир нэг мөр хэрэгждэг байх учиртай.

---

[10] Финляндын Зөвлөх групп, Монголын Ойн судалгааны нийгэмлэг ТББ, TA-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр Ойн ангийн чадавхын үнэлгээний тайлан, 2022

[11] Мөн тэнд

Дээр дурдсан үнэлгээнээс үзвэл нийт судалгаанд хамрагдсан 107 ойн нөхөрлөлүүдийн 45 орчим хувь нь сумынхаа ИТХ-д ажлаа жил бүр тайлагнадаг, 23 хувь нь огт тайлагнадаггүй бол 8.4 хувьд хааяа, 12.15 хувь нь заримдаа, 11.2 хувь нь ихэнхдээ танилцуулдаг гэжээ.

Эндээс товч дүгнэвэл ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг тогтмол буюу жил бүр үнэлж дүгнэх механизмыг хангалттай түвшинд хэрэгжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага тулгамдаж байна.

Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн үү?

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил нь онцгой байдал, орон нутгийн захиргаа зэрэг олон талын оролцоотой хэрэгжинэ. Ойн нөхөрлөлийн хувьд гэрээгээр эзэмшиж буй ойн сангийн тодорхой хэсэгт түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд эдгээр үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ёстой. Үнэлгээ хийж үзвэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах ажилд оролцдог уу гэсэн асуултад оролцогчдын 54 орчим хувь нь ойн түймрийн улиралд бүх гишүүд гал түймрийн эргүүл, хяналтад бүрэн оролцдог, эсвэл нөхөрлөл байгуулагдсанаас хойш ойн түймэр гараагүй гэж хариулсан байна. Түүнчлэн 30 дээш хувь нь ойн түймэр унтраахад бүх гишүүдийн 60-аас доошгүй хувь нь оролцож байсан гэж хариулсан. Мөн ихэнх ойн нөхөрлөлийн гишүүдийн 60-аас доошгүй хувь нь ойн түймэр унтраах гар багаж, техник хэрэгсэл бэлтгэсэн гэж хариулсан. Түүнээс гадна, үнэлгээнд оролцогчид ойн биологийн олон янз байдал нэмэгдсэн, ойн түймэр гарах, хууль бусаар мод бэлтгэх, хортон шавж тархах эрсдэл буурсан гэж хариулсан.

Нөгөө талаас ойн нөхөрлөлүүд зөвхөн ойн түймэр бус, хууль бус мод бэлтгэл, хортон шавжаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ч орон нутгийн засаг захиргааны зүгээс тэдэнд ямар ч урамшуулал байхгүй байгаа нь тэдний идэвх буурах үндсэн шалтгаан болж байна.

Дээрх хуулийн зохицуулалтын хувьд ой, хээрийн түймрээс хамгаалах ажлыг ойн нөхөрлөл өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр заасан нь хэрэгжих боломжийг хязгаарлаж байна. Өмнө дурдсанаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нь төрийн чиг үүргийн олон төрлийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, ойн нөхөрлөл, иргэдийн оролцоотой хэрэгждэг ажил юм. Тухайлбал, ОТХ-ийн 18.2.10 - 18.2.14 дэх заалтад ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг тусгаж өгсөн бөгөөд ойн нөхөрлөлд өөрийн хөрөнгөөр энэ ажлыг давхар гүйцэтгэх үүргийг хүлээлгэсэн нь эрх зүйн хэм хэмжээний давхардал үүсгэж буй юм. Нөгөө талаас ойн нөхөрлөлийн хувьд зөвхөн ойн сангийн тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хариуцан хамгаалж буй иргэдийн сайн дурын нэгдэл тул эдгээр олон субъектийн өмнөөс хөрөнгө гаргаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зохимжгүй. Түүнчлэн хуулийн этгээдийн эрхгүй, сайн дурын нэгдлийн шинжтэй ойн нөхөрлөлүүдэд ой, хээрийн түймрээс хамгаалах чиглэлээр арга хэмжээ авах санхүүгийн болон мэргэшсэн байдлын чадавх бий эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэ талаар удаах хэсгүүдэд авч үзнэ.

Ойн нөхөрлөл нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн менежментийн төлөвлөгөөний дагуу тасралтгүй үйл ажиллагаа явуулахуйц чадамжтай юу?

Ойн нөхөрлөлд ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зэрэг олон талын үүргийг хууль тогтоомжоор хүлээлгэсэн боловч эдгээрийг хэрэгжүүлэх чадавх бүрдсэн эсэх, энэхүү чадавх бэхжихэд дэмжлэг болохуйц хууль тогтоомжийн зохицуулалт бий эсэх, тэдгээр нь үр нөлөөтэй хэрэгждэг эсэхийг тодруулах шаардлагатай.

Ойг нөхөн сэргээх, хамгаалах талаар ойн нөхөрлөлүүдийн хийж буй ажлын талаар судалсан дүнгээс үзэхэд нийт ойн нөхөрлөлүүдийн 25 орчим хувь нь байгалийн сэргэн ургалтад туслах ажил огт хийж байгаагүй, 62 хувь нь 0.1-ээс 5 хүртэлх га, харин 13 хувь нь

5 га-аас дээш талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн байна. Ойн нөхөрлөлүүдийн байгалийн сэргэн ургалтад туслах гол ажил нь бэлчээрийн менежмент хийх бөгөөд зарим нөхөрлөлүүд тодорхой газрыг хашиж малд идэгдэхээс хамгаалсан бөгөөд ойн нөхөрлөлүүдийн хийж чадах хамгийн амархан ажил бол малын бэлчээрлэлтээс өсвөр моддыг хамгаалах үйл ажиллагаа болох нь тодорхой харагдаж байна. Ойн нөхөрлөлүүдийн ойг хамгаалснаас хойш тэдний хариуцсан нутаг дэвсгэр дээрээ байгалийн сэргэн ургалт эрчимтэй явагдаж байгаа бөгөөд ойн сангийн сэргэн ургалт явагдах боломжтой газруудын 21-60% -д байгалийн сэргэн ургалт явагдаж байна гэж ихэнх нөхөрлөл хариулсан. Байгалийн сэргэн ургалтыг дэмжих нь ойн талбайг нэмэгдүүлэх хамгийн ашигтай, зардал багатай хувилбар байхаар байна. Үнэлгээнд хамрагдсан ОН-үүдийн 59 орчим хувь нь мод үржүүлгийн газаргүй, зөвхөн 10 хувь нь 20,000-аас дээш тооны тарьц, суулгацтай гэж хариулсан байна. Мөн ойн нөхөрлөлүүдийн 36-аас дээш хувь нь ойжуулалт, нөхөн сэргээлт тал дээр огт туршлагагүй бол ОН-үүдийн 7.5 орчим хувь нь 4 га-аас дээш талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил хийдэг байна. Үлдсэн ойн нөхөрлөлүүдийн хувьд 0.1 га-аас 4 га хүртэл ойжуулалт, нөхөн сэргээлт хийж байсан туршлагатай байсан.

Ойн нөхөрлөлүүдийн санхүүгийн чадавхын байдлыг судалж үзэх нь зүйтэй. Санхүүгийн чадавхын хувьд ойн нөхөрлөлүүд сул байна. Өмнө дурдсанаар ойн нөхөрлөлүүд нь хуулийн этгээдэд тооцогддоггүй, гэрээний үндсэн дээр бий болсон иргэдийн хамтрал хэлбэртэй бөгөөд улсын бүртгэлтэй татварын дугааргүй тул ашиг олох үйл ажиллагаа нь маш хязгаарлагдмал байна. Нөхөрлөлийн дундын сан, орлого бий болгох үйл ажиллагаа, ой хамгаалал, нөхөн сэргээлтэд гардаг зардлыг тодруулж үзвэл судалгаанд хамрагдсан ойн нөхөрлөлүүдийн 44% нь дундын сангүй, 22.4% нь 1 сая төгрөгөөс бага, 17% нь 3.1-10 сая төгрөг, ердөө 3% нь 10 сая төгрөгөөс дээш дундын сантай байна. Нөгөө талаас ОН-үүдийн 36 орчим хувь нь үндсэндээ орлогогүй, ердөө 7,48 хувь нь 10 сая төгрөгөөс дээш орлоготой байна. Санхүүгийн хувьд чадавх сул байгаа нь ойн тогтвортой менежментэд хувь нэмэр оруулж ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх чадавхтай нь шууд холбогдох бөгөөд иймд ойн нөхөрлөлүүдийг санхүүгийн хувьд чадавхжуулахын тулд тодорхой урамшууллын механизм бий болгох аргыг хуульд тусгах шаардлагатай.

Нөгөө талаас сум орон нутгийн түвшинд ойн нөхөрлөлүүдийг дэмжих, хамтран ажиллаж байгаа эсэх нь тэдгээрийн үйл ажиллагаа амжилттай явагдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Сум/сум дундын ойн ангиуд ой модтой холбоотой бүхий л үйл ажиллагаануудад ойн нөхөрлөлүүдэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажилладаг. Үүнд ойн нөхөрлөлийг шинээр байгуулах, хариуцсан ойн сангийн зураглал хийх, ойн менежментийн төлөвлөгөө гаргах, чадавхжуулах сургалтууд зохион байгуулах зэрэг ордог.

Ойн ангиуд байгуулагдсан цагаас эхлэн ОН-үүдэд ойн цэвэрлэгээ, талбайн хилийн заагийг тогтоох, мод үржүүлгийн газарт мод тарих, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн түймэр, хортон шавжийг хянах гэх мэт мэргэжил аргазүйн тал дээр нөхөрлөлүүдийг чадавхжуулснаар ой хамгааллын менежмент ихээхэн үр дүнтэй болсон байна. Түүнчлэн ОН-үүд ойн аж ахуйтай холбоотой сургалт, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд 70-аас дээш хувь нь хагас жил дотроо оролцдог гэсэн бөгөөд үүнд ойн ангитай хийдэг уулзалт, зөвлөгөө, хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийн чадавхжуулах сургалт, дэмжлэг, оролцооноос хамаарч байна.

Сумын засаг даргаас дэмжлэг авдаг талаар асуухад 46 хувь нь хэзээ ч дэмжлэг авч байгаагүй, зөвхөн 6 хувь нь маш сайн дэмжлэг авдаг гэж хариулсан. Мөн ялгаагүй сумын ИТХ-аас ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэггүй нь харагдаж байна. Үндсэн хуулиар байгалийн баялаг төрийн нийтийн өмч байдаг тул өмчийн эзэн болох орон нутгийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэхгүй тохиолдолд хэдийгээр олон нөхөрлөл байгуулагдсан боловч үйл ажиллагаа нь суларч, идэвхгүй болж байна.

Үнэлэх хэсэг	**23 дугаар зүйл.Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа**

	23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллага нь өмчийн аль ч хэлбэртэй байж болох бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна: 23.2.1.ойн баялгийн нөөцийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх; 23.2.2.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг гүйцэтгэх, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх; 23.2.3.ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаа явуулахаас гадна бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх; 23.2.4.өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойн мэргэжлийн байгууллагууд нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж чадах тоогоор байгуулагдаж тогтвортой ажилладаг уу? - Ойн мэргэжлийн байгууллага нь ойн баялгийн нөөцийг хамгаалах, ойн санг гэрээгээр эзэмшиж зохистой ашиглах, нөхөн сэгээх, үржүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлдэг үү? - Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллагуудын тоо? - Ойн мэргэжлийн байгууллагын өнөөгийн чадавх дээрх үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай юу ?

Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт зааснаар ойн мэргэжлийн байгууллага нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрхийг холбогдох хуулийн дагуу авсан аж ахуйн нэгж, байгууллага юм. Тодруулбал, ойн мэргэжлийн байгууллага нь ойн нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагааг нарийн мэргэжлийн үндсэн дээр эрхэлдэг байгууллага байна. Ийм ч учир мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.23-т зааснаар ойн мэргэжлийн байгууллагын эрхийг Ойн газраас олгох бөгөөд ийнхүү эрх олгохдоо Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”-ын 3.5, 3.11, 3.12 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2013 оны А-223 дугаар тушаалаар батлагдсан журмыг баримталдаг.

<u>Ойн мэргэжлийн байгууллага нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхүйц чадамжтай юу?</u>

2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд ойн мэргэжлийн байгууллагын эрх авсан 952 аж ахуйн нэгж байна. Үүнээс: ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах чиглэлээр 85, ойд арчилгаа цэвэрлэгээ хийх 418, мод үржүүлэг, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр 356, ойн тооллого, ой зохион байгуулалтын чиглэлээр 19, ойн дагалт баялгийг хамгаалах, ашиглах чиглэлээр 40, ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэмцэх чиглэлээр 32 аж ахуйн нэгж, байгууллага ойн мэргэжлийн байгууллагын эрх авсан байна. Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн дийлэнх хэсгийг ойн арчилгаа цэвэрлэгээ, ойжуулалт, нөхөн сэргээлт эзэлж байгаа нь ойн салбарт ойжуулалт, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхол мэргэжлийн байгууллагуудын дунд нийтлэг байгааг харуулж байгаа юм.

Хуулийн этгээдийн бүртгэлийн хувьд дээрх дүр зураг харагдаж байгаа боловч бодит практикт ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй нөхцөл байдал, чадавх өөр байдалтай байна. Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн сангийн мэдээллээр 2021 оны IV улирлын байдлаар байдлаар ойн аж ахуй, мод бэлтгэлийн салбарт 1,006 аж ахуйн нэгж бүртгэгдсэн боловч тогтмол үйл ажиллагаа явуулдаг 386 аж ахуйн нэгж байгууллага байгаа бол 249 нь үйл ажиллагаа огт явуулж байгаагүй, 312 нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 59 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон байна. Доорх графикт үзүүлснээр зөвшөөрөл бүхий бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо

тасралтгүй нэмэгдэж байгаа бол үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн тоо буурах хандлагатай байна.[12]



Эндээс эдгээр ойн мэргэжлийн байгууллага нь ойн аж ахуйн чиглэлээр хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхтай юу гэсэн асуулт зайлшгүй тавигдана. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “ТА-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр” төслийн хүрээнд ойн ашиглалт, нөхөн сэргээлт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 459 аж ахуйн нэгжүүдээс 100 мэргэжлийн байгууллагыг сонгон санал асуулга авчээ.[13] Үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлбол ойн үйлдвэрлэлийн ашиглалтын чиглэлээр 13, ойн арчилгаа цэвэрлэгээ, ойжуулалт, нөхөн сэргээлтийн чиглэлээр 85, ойн дагалт баялгийн ашиглалтын чиглэлээр 2 компани хамрагдсан бөгөөд дараах асуудал тулгамдсан талаар дурджээ.

Ойн мэргэжлийн байгууллагууд ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл, хүндрэлүүдийн хувьд дийлэнх нь техник тоног төхөөрөмж хангалтгүй байдаг нь ажлын гүйцэтгэлд саад учруулдаг гэж хариулсан бөгөөд нийт хариултын 20%-ийг эзэлж байв. Түүний дараа мөн адил санхүүгийн чадавх хангалтгүй (19%), хүний нөөц хангалтгүй (17%), идэвх зүтгэл, санаачилга хангалтгүй (11%) байдал, орон нутгийн засаг захиргааны буруу шийдвэр, хариу арга хэмжээ (11%), Ойн менежментийн төлөвлөгөөний бодит бус боловсруулалт (9%), “бусад” хэмээх ангилалд дурдсан саад бэрхшээлүүд нь 7%-ийг эзэлж байсан бол БОАЖЯ-ны зохисгүй шийдвэр нь хамгийн бага хувь буюу 6%-ийг эзэлж байгаа нь СДОА-уудаас авсан судалгаанаас харагдаж байна (Зураг 5).

[12] Финляндын зөвлөх үйлчилгээний групп, Монголын ойн судалгааны нийгэмлэг ТББ, ТА-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр – Ойн мэргэжлийн байгууллагын үнэлгээний тайлан

[13] Байршлаар тодорхойлбол Завхан аймгаас 14, Архангай аймгаас 6, Өвөрхангай аймгаас 7, Сэлэнгэ аймгаас 12, Хэнтий аймгаас 10, Булган аймгаас 15, Хөвсгөл аймгаас 17, Төв аймгаас 3, Дархан-уул аймгаас 4 тус тус хамрагдсан.



Дээрх асуудлуудаас хүний нөөцийн чадавхын тулгамдсан асуудлыг эхний ээлжид авч үзвэл, судалгаанд хамрагдсан 100 аж ахуйн нэгжид нийт 1055 хүн ажилладаг бөгөөд нэг ойн мэргэжлийн байгууллага дунджаар 10 ажилтантай. (Зөвхөн Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн Төмөр замын дэр модны үйлдвэр л 144 ажилтантай бөгөөд үүнийг тооцож үзвэл дундаж ажилтны тоо 9 болж буурна) Нийт ажиллагсдын 807 /76 %/ нь эрэгтэй, 248 /24%/ нь эмэгтэй.



Аж ахуйн нэгжийн ажиллагсдын 60 % нь мэргэжилтэй ажилчид ба 68 % нь ойн сургалтад заримдаа хамрагддаг байна. ОМБ-ын хүний нөөц дутмаг, байнгын үйл ажиллагаа явуулдаггүй тул ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй. Ойн мэргэжлийн байгууллагууд ажилтнуудаа давтан сургах, мэргэшүүлэх сургалтад хангалтгүй хамруулдаг.

Хүний нөөцийн чадавх сул байгаа нь санхүүгийн чадавхтай шууд холбоотой. Аливаа байгууллага санхүүгийн зохих чадавхтай, түүнийг зарцуулж удирддаг зөв менежменттэй байсны үндсэн дээр л хүн хүч, техник технологийн хувьд бэхжинэ. Ойн мэргэжлийн байгууллагын санхүүжилтийн үндсэн эх үүсвэрээ ойн баялгийн ашиглалтаас олж авна. Улсын хэмжээнд ойн мэргэжлийн байгууллага сүүлийн 3 жилийн дунджаар жилд 400 м^3 мод ойгоос бэлтгэж байна. Сэлэнгэ аймгийн ОМБ-уудын жилд бэлтгэдэг модны хэмжээ харьцангуй илүү, дунджаар 1000 м^3-ээс дээш, Хөвсгөл аймгийн ОМБ-ууд 500 м^3 -ээс дээш байдаг бол Завхан, Архангай, Хэнтий



аймгийнх 100-300 м^3 байдаг байна. ОМБ-ууд зөвшөөрөл олгосон жилд бэлтгэх модыг дунджаар 4 сарын дотор бэлтгэж байна. Ойн мэргэжлийн байгууллагууд жилд дунджаар 179,0 сая төгрөгийн борлуулалт хийж, 124,0 сая төгрөгийн зардал гарган 27.0 сая төгрөгийн ашигтай ажилладаг байна. Орлогод эзлэх цалингийн зардал 43.6 %, зардалд эзлэх цалин 62.7 % байдаг байна. Түүнчлэн ОМБ дунджаар 209.6 сая төгрөгийн нийт хөрөнгө, 29.8 сая төгрөгийн өр төлбөр, 191.6 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна.

Энэ нь ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах, санхүүгийн чадавхтай болох, техник технологио шинэчлэх боломж нөхцөл олгодоггүй. Үүнээс шалтгаалан ойн мэргэжлийн байгууллагууд 30 жил орчим амиа аргацаасан байдлаар үйл ажиллагаа ирсэн. Мөн энэ нь хууль бус мод бэлтгэл, далд эдийн засгийг өөгшүүлж байж ч болзошгүйг анхаарах хэрэгтэй. Үүнийг шийдвэрлэх арга зам нь мод бэлтгэх зөвшөөрлийн одоогийн тогтолцоог өөрчилж ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг тогтолцоо руу шилжих явдал юм.



Ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн 100 м^3 мод тутамд 2 га ойжуулалтын ажил хийх үүрэгтэй байдаг. ОМБ-уудын ихэнх нь ойжуулалт, нөхөн сэргээлт хийдэг эсхүл зардлыг нөхөн сэргээлт хийдэг компанид төлдөг байна. Ихэнх ОМБ-ын гол ажил үүрэг бол ойд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх, мод бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал юм. Зарим сумдад ойн нөөц багатай, эсвэл ойн сан бүхий газар нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаардаг зэрэг шалтгаанаас үүдэж мод бэлтгэл бараг хийгдэх боломжгүй байдаг тул зөвхөн ойн арчилгаа, цэвэрлэгээний ажил хийгддэг. Ойн нөөц багатай, мөн ашиглалт бараг хийгддэггүй энэ нөхцөл байдал нь аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагууд оршин тогтноход хэцүү болгодог гэж СДОА-ууд мэдэгдэв.

Үнэлэх хэсэг	18.3.Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй: 18.3.1.ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах; 18.3.4. ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод үржүүлэх ажил эрхлэн модны үр, тарьц, суулгац худалдаалах, ойд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ тогтоох; 18.3.7.ойн баялгийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах; 18.3.8.аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох; 18.3.12.ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах; 18.3.13.ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих; 18.3.14.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах; 18.3.15.ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойн анги үйл ажиллагаагаа тогтвортой мэргэшсэн байдлаар явуулахад тулгамддаг асуудлууд юу вэ?

	- Сум дундын ойн ангийн хариуцаж байгаа ойн сангийн талбайд хангалттай ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага байгаа эсэх? - Ойн мэргэжлийн байгууллага нь ойн баялгийн нөөцийг хамгаалах, ойн санг гэрээгээр эзэмшиж зохистой ашиглах, нөхөн сэгээх, үржүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлдэг үү? - Ойн мэргэжлийн байгууллагын өнөөгийн чадавх дээрх үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай юу ?

<u>Ойн анги үйл ажиллагаагаа тогтвортой мэргэшсэн байдлаар явуулахад тулгамддаг асуудлууд юу вэ?</u>

СДОА нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ хэрэгжүүлэхэд ямар нэгэн саад бэрхшээл, хүндрэлтэй тулгардаг эсэхийг асуухад судалгаанд оролцогчид бүгд аливаа ажил, үүрэг гүйцэтгэх явцад тодорхой төрлийн ямар нэгэн хязгаарлалттай тулгардаг гэж хариулсан. Судалгаанд оролцогчдын ихэнх нь улс төрийн намын сонгуулийн дөрвөн жил тутамд төрийн албанд тодорхой хэмжээний халаа сэлгээ хийдэг байдал нь гол саад бэрхшээл учруулдаг гэж мэдэгдэв. СДОА-ийн даргыг мэргэжлийн бус хүмүүсээр байнга хольж, сольж байдаг нь ойн инженерүүд ажлаа эхнээс нь даргадаа тайлбарлаж, богино хугацаанд ажлаа ойлгуулж явуулах процесс нь ихээхэн хүндрэл учруулсаар байна. ОМТ-ний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээлүүдийг харьцуулж үзэхэд хамгийн их хувийг хүний нөөцийн дутагдал (22%), техник хэрэгслийн дутагдал (20%), төсөв, санхүүжилтийн дутагдал (19%), ажиллах нөхцөл (14%), мэргэшсэн боловсон хүчний хомсдол (12%), удирдлага, зохион байгуулалт (8%) хангалтгүй байх зэрэг хүчин зүйлс эзэлж байгаа бол бусад саад бэрхшээлүүд нийт хариултын 5 орчим хувийг эзэлж байна. “Бусад” саад бэрхшээлүүд гэсэн ангилалд ойн анги/ойн байгууллагуудын дарга нар эсвэл орон нутгийн засаг захиргааны дарамт, хууль бус үйлдлийг таслан зогсоох гэхэд СДОА-ийн албан тушаалтнуудын эрх/эрх мэдэл дутмаг байх явдал, орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлэхгүй байх явдал, ажлын байрны тогтворгүй байдал зэрэг багтана. Ажлын байрны нөхцөлийн хүндрэлтэй байдал гэдэг нь СДОА-ийн одоогийн байрлаж буй албан тасалгаа нь түр зуурынх/түрээсийн эсвэл орон нутгийн засаг захиргааны байрны нэг өрөөнд ажилладаг тул хэдийд ч шилжүүлэн суурьшуулах, хөөх магадлалтай гэсэн үг юм. Судалгаанд оролцогчид үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлийг бууруулахын тулд дараах саналуудыг гаргасан болно:

- Босоо удирдлагатай болж ойн агентлагт харьяалагдах;
- Хангалттай хэмжээний техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;
- Ажлын байр, орон тоо нэмэгдүүлж, хүний нөөцтэй болох;
- Одоо ажиллаж байгаа ойн инженерүүдийн чадавхыг нэмэгдүүлж, мэргэшсэн шинэ боловсон хүчин бэлтгэх;
- Төсөв нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхыг сайжруулах;
- Ажлын байрны таатай нөхцөл бүхий байнгын албан тасалгаа/оффистой болох нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Зураг 6. СДОА хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ хэрэгжүүлэхэд саад болж буй хүчин зүйлс



СДОА-ууд нь хүчин төгөлдөр ойн менемжентийн төлөвлөгөөтэй юу?

Судалгааны хүрээнд ярилцлагад хамрагдсан 36 СДОА-аас 12 СДОА-д одоогийн байдлаар хүчин төгөлдөр, батлагдсан ойн менежментийн төлөвлөгөө байхгүй байсан (Зураг 8). Үлдсэн 24 СДОА-ийн тус тус хариуцаж буй сумдын ихэнх нь ямар ч батлагдсан ОМТ-гүй, харин зөвхөн хэдхэн сумдад дөнгөж шинээр батлагдсан ОМТ бий гэж мэдэгдсэн. Одоогийн байдлаар ОМТ байхгүй гэсэн СДОА-ууд нэг бол ОМТ-г энэ жил боловсруулж байгаа, эсвэл шинээр боловсруулсан ОМТ-г аймаг, сумдын удирдлагуудад хүргүүлсэн хэдий ч батлагдахыг хүлээж байгаа гэсэн хариултыг өгсөн юм. СДОА-ууд ОМТ-г аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхнээр боловсруулдаг гэж мэдэгдсэн бөгөөд ОМТ-г өөрсдөө боловсруулж, бие даан хэрэгжүүлэх чиглэлээр илүү олон чадавхи бэхжүүлэх сургалтад хамрагдахыг хүсч байгаа талаар илэрхийлсэн. Одоогийн байдлаар хүчин төгөлдөр, батлагдсан ОМТ-тэй СДОА-уудын мэдээлснээр ОМТ-ний дундаж хугацаа нь дөрөв эсвэл таван жил байдаг (Зураг 9). Улс төрийн намын сонгуультай холбоотойгоор дөрвөн жил тутам дарга нар байнга солигддог тул ОМТ-ний хугацаа дөрвөн жил байдаг байна. . Нөгөө талаас ойн тогтвортой менежментийн хэрэгжүүлэхэд урт хугацаа шаардагддаг тул менежментийн төлөвлөгөөг хугацаатай болгож, хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизм хуулийн тусгах шаардлагатай байна.

Зураг 8. Одоогийн байдлаар хүчин төгөлдөр ОМТ байгаа эсэх



Зураг 9. ОМТ-ний дундаж хугацаа



<u>Одоогийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой юу?</u>

Төсөв хязгаарлагдмал, боловсон хүчний хүрэлцээ муу, сумдаас дэмжлэг байхгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж ОМТ-нд тусгасан үйл ажиллагааны 60-70 хувийг л хэрэгжүүлэх боломжтой байдаг хэмээн судалгаанд оролцогчид мэдэгдэв (Зураг 10). ОМТ-г зөвхөн СДОА-ууд ганцаараа хэрэгжүүлдэггүй, харин орон нутгийн засаг захиргаа/сумын ЗДТГ, ОМБ, ОН-үүд, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид зэрэг бусад оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлдэг. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ОМТ-г хэрэгжүүлэх үе шатанд бодлогын зөвлөмж, заавар зөвлөгөө өгөх тал дээр ажилладаг. ОМТ-нд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх тал дээр ямар нэгэн тусгай хяналтын механизм байхгүй гэж бүх СДОА-ууд мэдэгдсэн. Гэхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жил бүр ажлын гүйцэтгэлийн тайлан авах загвар илгээдэг боловч эргээд ойн ангиудад ямар ч санал хүсэлт өгдөггүй гэж СДОА-ийн 15 орчим хувь нь хэлж байв.

Зураг 10. ОМТ-нд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар



Сумын ойн менежментийн төлөвлөгөөтэй ОН, мэргэжлийн байгууллагын гэрээгээр эзэмшсэн талбайн менежментийн төлөвлөгөө хэр уялдаа холбоотой байдаг талаар ОМТ-тэй СДОА-уудаас асуухад ихэнхи нь сум, ОН, ОМБ-уудын ОМТ-г өөр өөр хувийн хэвшлийн байгууллагууд боловсруулсан тохиолдолд холбогдох ОМТ нь маш их зөрчилтэй, зөрүүтэй, алдаатай байдаг гэж хариулсан болно. Гадны байгууллагууд ойн мэдээллийн санд заасан модны төрөл, зүйлийн албан ёсны нэр томьёог андуурч бидэг, эсвэл менежментийн төлөвлөгөөнд ашигласан статистик мэдээлэл нь ойн тооллогын мэдээтэй зөрдөг гэх мэт зөрчлүүд илэрдэг талаар мэдэгдэв. Зарим тохиодолд жилд хэдэн шоо метр мод бэлтгэх заавар нь статистик мэдээлэлд тулгуурладаггүй. Мод бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй ОМБ нь ОМТ боловсруулж буй аж ахуйн нэгжээс мод бэлтгэхэд шаардлагатай ойн нөөцийн хэмжээг

илүү ихээр тавьж өгөхийг хүсэхэд тухайн аж ахуйн нэгж менежментийн төлөвлөгөөг боловсруулсны төлбөрөө авахын тулд тус хүсэлтийг биелүүлж, илүү их модны нөөц тавьсан байдаг.

Харин эсрэгээрээ, СДОА нь аймаг, сум, ОН, ОМБ-уудын ОМТ-г тус тус боловсруулсан тохиолдолд бүхий л ОМТ-нд тусгасан үйл ажиллагаа болон статистик тоон үзүүлэлтүүд хоорондоо харилцан уялдаа холбоотой байдаг. СДОА-ууд өөрсдийн хариуцсан ойн санд тухайн жил бүр хэчнээн га талбайд ямар төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлж, үйл ажиллагаануудыг уялдуулан төлөвлөж ОМТ-г боловсруулахын тулд хүчин чармайлт гаргадаг. Тэдгээр СДОА-ууд сүүлийн хэдэн жил менежментийн төлөвлөгөөнүүдийг харилцан уялдаа холбоотой боловсруулах тал дээр ажиллаж ирсэн. Гэвч гол асуудал нь ОН-үүд тухайн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа явдал юм. Сум орон нутаг хүртэл менежментийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаар ойлголтгүй, ийм төлөвлөгөө байдаг эсэхийг ч мэдэхгүй байна. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувьд, ОМБ-уудад ойн нөөц багатай ойн сан буюу хамгаалалтын бүсийн ойд үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр хуваарилсан байдаг бол ОН-үүдэд ихэвчлэн их нөөцтэй ойн санг эзэмшиж, ойн аж ахуйн арга хэмжээ явуулдаг гэж зарим СДОА-ууд дурдаж байв. Ойн арчилгаа, цэвэрлэгээ зэрэг үйл ажиллагааг ОН-үүд өөрсдөө хийдэг. Хувийн аж ахуйн нэгжүүд, ОМБ-ууд ОН-ийн эзэмшиж буй нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тохиолдолд харилцан тохиролцдог. Ойн анги энэ асуудлыг ямар ч байдлаар зохицуулдаггүй.

<u>Ойн ангиуд нь үйл ажиллагаандаа шаардагдахүйц санхүүжилтийг авч чадаж буй эсэх?</u>

Ойн ангийн дарга нар болон инженерүүдтэй хийсэн ярилцлагад орон нутгийн засаг захиргаа, сумдын удирдлагуудаас ОМТ-г хэрэгжүүлэхэд ямар нэгэн санхүүжилт авч байгаа эсэх, жилийн төсвийн хэмжээ, ойн аж ахуйн үйл ажиллагааг санхүүжүүлж буй эх үүсвэр, ойн менежментийн үйл ажиллагаа болон байгууллагын менежмент, бусад зардалд нийт төсвийн хэдэн хувийг зарцуулж буй талаар асуултуудыг тавьсан. Мөн ойн ангиуд жил бүр үйл ажиллагаанаасаа олсон орлогын хэмжээ, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх бусад арга замын талаар СДОА-уудаас санал бодлыг нь авч, төсөв бүрдүүлэх хэсэгт дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг хүссэн юм.

Ярилцлагад хамрагдсан 36 СДОА-аас 29 СДОА нь сумын удирдлагуудаас ямар ч санхүүжилт, санхүүгийн дэмжлэг авдаггүй гэж хариулсан бол 7 СДОА нь сумын удирдлагаас тодорхой хэмжээний санхүүжилт авдаг гэж хариулсан байна (Зураг 12). Санхүүжилт авч байгаагаа илэрхийлсэн оролцогчид санхүүгийн дэмжлэгийн хэмжээ бага, менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээнд хүрэлцдэггүй гэж мэдэгдсэн. Ойг хамгаалах арга хэмжээ, түймэр, хортон шавьжны судалгаанд тодорхой хэмжээний төсөв төсөвлөдөг. Судалгаанд оролцсон нэг СДОА хавар, намрын улиралд сумдаас шатахуун болон автомашины дэмжлэг авдаг тухай дурдсан бол өөр нэг СДОА ОтХ-ийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах, сургалтын мэдээлэл хуваалцах, иргэдийн оролцоотой үйл ажиллагаа явуулах гэх мэт шаардлагатай арга хэмжээнүүдэд санхүүжилт авч буйгаа мэдэгдэв. Тухайлбал, ИТХ-аар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ойжуулах, түймрийн аюулаас хамгаалах арга хэмжээний талаар хэлэлцээд төсөв хуваарилдаг. Хэд хэдэн СДОА нь ОМТ-г боловсруулахад санхүүгийн дэмжлэг авдаг гэж мэдэгдсэн боловч ОМТ-д тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэх үед ямар ч санхүүжилт, санхүүгийн дэмжлэг байдаггүй хэмээн тодруулсан юм.

Харин эсрэгээрээ, ихэнх СДОА-ийнхан санхүүгийн дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлсэн ч санхүүжилт өгдөггүй, эсвэл төлөвлөгөөнд төсөв тусгагдсан хэдий ч бодит санхүүжилт нь зохих ёсоор шилждэггүй гэсэн хариултыг өгсөн. Харин ойн ангиас ойн менежментийн үйл ажиллагааг санхүүжүүлэх саналыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, тус асуудлыг оруулж, СДОА-ийн жилийн төсвийн сангаас тусад нь төсвийг баталснаар хэрэгжих боломжтой байдаг. Энэ нь ойн ангид шууд тухайн төсвийг шилжүүлэхгүйгээр, худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу тендер хэлбэрээр

явагдана гэсэн үг юм. СДОА-ийн хоёр нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангаас тодорхой хэмжээний санхүүжилт хааяа авдаг гэж мэдэгдэв. Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд Засаг дарга нөөц хөрөнгөөс мөнгө татаж түймэр унтраах ажлыг санхүүжүүлдэг. Түүнээс гадна сумдад ойжуулалт хийх ажилд төсвөөс зарцуулдаггүй. 2019 оноос хойш орон нутгийн төсвийн хөрөнгөөр хортон шавжтай тэмцэх ажлыг нэг СДОА явуулж байгаа бөгөөд өөрсдөө судалгаа хийдэг гэж тус СДОА нь мэдэгдсэн.

Зураг 12. Сумдаас санхүүжилт авдаг СДОА-ийн тоо



Монгол Улсад нийт 46 ойн анги байгаагаас 41 СДОА, 5 сумын ойн анги байна. Хуулийн этгээдийн хэлбэрийн хувьд төсөвт байгууллага 16, УТҮГ 8, ОНӨААТҮГ 22 байна.

Эдгээр 46 ойн анги 17,187,291.6 1 га талбайд Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтын хүрээнд ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байна. 1 ойн анги дунджаар 393,509 га талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бол хамгийн их буюу 1,664,768 га талбайд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум дахь сум дундын ойн анги, хамгийн бага буюу 13.4 га талбайд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Борхойн Баян Бүрд ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулж байна.

46 ойн ангид нийтдээ 6,646,411,429 төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд үүнээс орон нутгийн төсвөөс 5,468,832,591 төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,177,580,838 төгрөг олсон. 1 ойн анги дунджаар орон нутгийн төсвөөс 140 сая төгрөгийн санхүүжилт авч, 31 сая төгрөгийн үйл ажиллагааны орлоготой ажиллаж байгаа бол Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ойн анги 205,561 га талбайд үйл ажиллагаа явуулж, орон нутгийн төсвөөс санхүүжилт аваагүй боловч өөрийн үйл ажиллагааны орлогоос 221,111,770 төгрөг олсон байна. Өмнөговь аймгийн сум дундын ойн анги 2040 га талбайд үйл ажиллагаа явуулж орон нутгийн төсвөөс 1,417,469,700 төгрөгийн санхүүжилт авсан байна.

Бүх ойн ангид нийт 384 ажилтан ажиллаж байгаа бөгөөд 1 ойн анги дунджаар 9.4 ажилтантай байна. Өмнөговь аймгийн сум дундын ойн анги хамгийн их буюу 96 ажилтантай бол Сэлэнгэ аймгийн Орхон сум дахь сум дундын ойн анги хамгийн бага буюу 3 ажилтантай байна. 46 ойн анги нийтдээ 4,200,604,697 төгрөгийг цалингийн зардалд зарцуулжээ. 1 ажилтны сарын дундаж цалин ХХОАТ, НДШ-ийн өмнөх дүнгээр 1,019,467 төгрөг байна.

Орлого бий болгох үйл ажиллагааны талаар асуухад СДОА-уудын хэрэгжүүлж буй хамгийн нийтлэг үйл ажиллагаа бол мод бэлтгэлийн талбай тусгаарлалт, тарьц, суулгацын худалдаа хэмээн хариулав. Хэд хэдэн СДОА үрийн жилээс хамааран модны үр худалдаалдаг, зарим нь ойн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, менежментийн төлөвлөгөө боловсруулж орлого олдог байна.

СДОА үйл ажиллагаанаасаа олж буй жилийн орлогын хэмжээг авч үзвэл 14 СДОА нь 5,000,000 төгрөгөөс бага хэмжээний орлого олдог гэсэн бол зөвхөн нэг СДОА 50,000,000 гаруй төгрөгийн орлого олдог хэмээн мэдэгдсэн болно. Аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа явуулах хүний нөөц хомс, чанарын шаардлага хангахгүй техник хэрэгсэл, мэргэжлийн инженер, боловсон хүчин дутагдалтай зэргээс шалтгаалан СДОА-ууд улирлын чанартай ойн аж ахуйн ажлууд, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд саад бэрхшээлтэй тулгардаг хэмээн онцолсоор байв.



Санхүүгийн чадавхыг бэхжүүлэх арга замын талаар СДОА-ийн санал бодлыг асуухад дийлэнх нь төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувиар санхүүжиж, бие даасан ойн аж ахуй эрхлэх нь санхүүгийн чадавхыг сайжруулна гэж үзсэн (Зураг 18). СДОА-ууд нэг тэрбум модны аяны хүрээнд одоогийн мод үржүүлгийн газруудынхаа нөхцөл байдлыг сайжруулж, илүү олон тарьц, суулгац ургуулах шаардлагатай байгааг онцлон хэлэв. Түүнчлэн, мод үржүүлгийн газруудыг нэмэгдүүлж, МҮГ-т ажиллах боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах замаар санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой гэв. Гэхдээ гол асуудал нь олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг. Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойн зурвас байгуулах зэрэг үйл ажиллагаа эрхэлж, орлого олох боломжтой болсноор, СДОА-ууд олсон орлогоо өөрсдөө захиран зарцуулахыг хүсч буйгаа илэрхийлсэн. Ойн нөөц бага учраас орлого олох боломж хомс байдгийг зарим СДОА-ууд хэлж байв. Үүнтэй холбоотойгоор ойн нөөц хомс байдаг СДОА-ууд аж ахуйн нэгжийн бүтэцтэй болсон ч ашиггүй гэж зарим нь үзсэн.

СДОА-аас гарсан өөр нэг чухал санал бол ойн ангийн орон тоог нэмэгдүүлэх явдал байв. Гол асуудал нь Монголын ойн салбарт хийх ажил их байгаа ч боловсон хүчин дутмаг байна. Тогтвортой, үр ашигтай ажиллахын тулд мэргэшсэн, хангалттай тооны хүний нөөцтэй байх нь хамгийн чухал гэдгийг СДОА-ууд илэрхийлсэн. Мөн ярилцлагын үеэр цалингийн асуудлыг ч мөн онцлон хэлсээр байв. Одоогоор байгаль хамгаалагчдын цалинг нэмэгдүүлэх тухай л яригдаж байгаа ч ойн ангийн инженерүүд газар дээр нь ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан ойг үр ашигтай хамгаалах, байгалийн нөхөн сэргэлтийг дэмжихийн тулд ойн ангийн инженерүүдийн цалинг нэмэгдүүлэх, ажлын сайн гүйцэтгэлийг урамшуулах нь зүйтэй гэж СДОА-ууд мэдэгдэв.

Байгалийн нөөц ашиглах, хэрэглэгчийн эрхтэй холбоотой бүхий л хураамж, хэрэглээний мод, түлээний мод бэлтгэх зөвшөөрлийн хураамж, ОН-үүд ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, унанги мод бэлтгэх зөвшөөрлийн хураамж, ОМБ-ууд мод бэлтгэлийн хураамжийг орон нутгийн засаг захиргаа хурааж авдаг. Ойн тухай хуульд заасны дагуу тэд нийт цуглуулсан төлбөрийн орлогоос 85 хувийг Ойн ангид буцааж, ойд эргээд хөрөнгө оруулалт хийх ёстой байдаг. Гэвч ийм зүйл болоогүй удаж байна. Сүүлийн жилүүдэд буцааж олгосон төлбөрийн орлогын % нь 35-40% байсан боловч энэ нь буцааж олгосон мөнгө биш байсан. Учир нь орон нутгийн засаг захиргаа тухайн мөнгийг ойтой холбогдолтой бүхий л үйл ажиллагаанд ашиглах боломжтой. Ярилцлагад хамрагдсан 36 ОА-ын дарга нарын 30 нь сүүлийн жилүүдэд тэдний ОА-д мөнгө буцаан олгоогүй гэсэн байна.

Ойн ангиудын удирдлага, зохион байгуулалт оновчтой байж чадаж байна уу?

Ойн ангиудын холбогдох албан тушаалтнуудаас тухайн ойн анги нь удирдлага, зохион байгуулалт, бүтцийн хувьд хаана харьяалагдах нь зүйтэй талаарх санал дүгнэлтийг асуухад санал асуулгад оролцогчид бүгд ойн салбар нь босоо бүтэц, зохион байгуулалттай болж, шинээр байгуулж буй Ойн агентлагт харьяалагдах нь зүйтэй гэж хариулсан. СДОА-ууд мөн холбогдох бүхий л саад бэрхшээл, асуудлууд нь тогтворгүй ажлын байртай холбоотой болохыг онцлон хэлж байв. Хэт их улс төрийн нөлөөнөөс хамааралтай шийдвэр, халаа сэлгээ ихтэй учраас ойн ангиудыг татан буулгах, шинээр байгуулах зэрэг асуудал байнга гардаг. Түүнчлэн, орон нутагт намын сонгуультай холбоотойгоор ойн анги, засаг захиргаанд байнга халаа сэлгээ хийдэг. Аливаа сургалтад хамрагдсан ойн ангийн ажилтнууд ажилдаа мэргэжлийн болж эхэлж байхад тэдгээр ажилтнуудыг хольж, солих, ажлаас нь чөлөөлөх асуудал гарсаар байдаг байна.

Одоогоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар зөвхөн аймгийн бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд анхаардаг бөгөөд СДОА-уудад мэргэжлийн дэмжлэг барагтаа үзүүлдэггүй. Ойн байгууллага босоо удирдлагад шилжсэнээр аливаа мэргэжлийн байгууллага шууд оролцож, хамтран ажиллах боломжтой болно.

2012 оны Ойн хуульд буй ойн ангитай холбоотой алдаатай зүйлийг эрх зүйн хувьд залруулахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай гэж үзэж байна.

1. Ойн анги ойн төрийн өмчлөл, менежмент, хяналт, зохицуулалтын хэрэгжилтийг газар дээр нь буюу ойн санд хариуцдаг байгууллага тул түүнийг төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд хамруулан, төрөөс байгуулж, санхүжүүлж, үйл ажиллагааны баталгааг тогтоох ёстой.

2. Ойн анги төрийн байгууллага тул түүний удирдлагыг ойн ангийн дээд шатны төрийн байгууллагаас томилох ёстой. Ойн анги үндсэн чиг үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах ойн мэргэжлийн дээд шатны байгууллага нь Засгийн газрын Ойн агентлаг юм. Энэ үүргийг аймгийн Засаг дарга болон бусад этгээдээс хэрэгжүүлэх боломжгүй. Засгийн газрын ойн агентлаг нь ойн ангитай, чиг үүрэг, бодлого, манлайллын хувьд нэгдэж Монгол Улсын ойн менежментийн ажлын үр дүнг Засгийн газар, УИХ-ын өмнө хариуцна. Ойн ангийн даргыг Ойн агентлагаас томилох, халах, чөлөөлөхөд аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын даргатай зөвшилцөх учиртай. Учир нь ой сан нь орон нутгийн иргэдийн тогтвортой амьдралтай холбоотой байдаг тул ойн ангийн удирдлага тухайн орон нутгийн ашиг сонирхлыг үйл ажиллагаандаа харгалзан үзэх зайлшгүй хэрэгцээтэй болдог. Энэ тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга томилгоонд оролцох шаардлагагүй ба Засаг

дарга ойн ангитай харилцах харилцаанд түүнийг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар төлөөлөн, тухайн ажлыг Засаг даргын өмнө хариуцна.

3. Ойн анги төрийн байгууллага тул аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг зогсоох хэрэгтэй. Ойн анги аж ахуйн үйл ажиллагаа явуулах практик ойн ангийн үлгэрчилсэн дүрэм болон анх байгуулсан орон нутгийн байгууллагын шийдвэрээр ихэвчлэн тогтоосон практик юм. Түүний эрхэлдэг аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий ойн мэргэжлийн байгууллага буюу хувийн хэвшлээр эрхлүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд цалингийн сан хэмнэгдэнэ, ойн анги, түүний албан хаагчдын эрх зүйн байдал тодорхой болно. Ойн ангийн албан хаагчид төрийн захиргааны албан хаагчийн цалингийн сүлжээгээр цалинжиж, нийгмийн баталгаа нь одоогийнхоос сайжирна гэж үзэж байна.

2.5. ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

Үнэлэх хэсэг	**24 дүгээр зүйл.Ойг хамгаалах арга хэмжээ** 24.1.Ойг хамгаалах арга хэмжээнд ойг ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, удмын санг хамгаалах арга хэмжээ багтана. 24.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэрийнхээ ой бүхий газрын доройтсон хэсэгт ойн санг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор гурав хүртэлх жилийн хугацаагаар ашиглалтын үйл ажиллагааг зогсоож болно. **26 дугаар зүйл.Ой, хээрийн түймрээс хамгаалах** 26.1.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 26.2.Түймрийн аюултай үед иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ой, хээрийн бүс нутагт дараах үйлдэл хийхийг хориглоно: 26.2.1.өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлэх; 26.2.2.мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэх; 26.2.3.шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн болон бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаях; 26.2.4.тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог, хаягдал, үнс, чүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашиглах. 26.3.Ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм норматив дагуу бүрдүүлэх ба тэдгээрийг түймэр гарсан үед ашиглахад бэлэн байлгана. **27 дугаар дүгээр зүйл.Ойг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах** 27.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга ойг хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авна. 27.3.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 27.4.Хөнөөлт шавж, өвчний судалгаа явуулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ. 27.5.Ойд хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэхэд төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрснөөс бусад химийн бодис, биологийн бэлдмэл ашиглахыг хориглоно. **28 дугаар зүйл.Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хилийн зурвас гаргах, сэргээх**

	28.1.Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, экологийн тэнцлийг хадгалан хамгаалах зорилгоор энэ хуулийн 28.2.1-д заасан арчилгааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллага, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэн гэрээгээр хийнэ. 28.2.Ойд хийгдэх арчилгаа, цэвэрлэгээний ажлыг дараах байдлаар санхүүжүүлнэ: 28.2.1.ойд гэрэлжүүлэх, тохируулах арчилгааг улсын төсвийн хөрөнгөөр; 28.2.2.энэ хуулийн 28.2.1-д зааснаас бусад төрлийн арчилгаа болон цэвэрлэгээний ажлыг тухайн ажлыг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр. 28.3.Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд ойд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын хэмжээг Засаг даргынх нь саналыг үндэслэн аймаг, нийслэлээр тогтооно. 28.4.Ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/ арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэх модонд эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно. 28.5.Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 28.6.Хил хамгаалах байгууллага хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу улсын хилийн шугам дайран гарсан ойд улсын хил тод харагдахаар зурвас гаргах, сэргээх ажлыг төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр хийх бөгөөд дээрх зурвасаас гарсан модыг хуульд заасны дагуу ашиглаж болно. **29 дүгээр зүйл.Ойд хориглох үйл ажиллагаа** 29.1.Ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс ойг хамгаалах зорилгоор дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 29.1.1.насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, заг, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тэс болон чацаргана, мойл зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх; 29.1.2.төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос хуш, гацуур, нарсыг бэлтгэх, ашиглах; 29.1.3.ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх; 29.1.4. ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах; 29.1.5.ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх; 29.1.6.энэ хуулийн 14.1, 14.2-т заасан эрх бүхий байгууллагатай зөвшилцөхгүйгээр эзэмшлийн ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулах; 29.1.7.иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрөлгүйгээр ойгоос мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан агнах, түймрийн аюултай үед зохих зөвшөөрөлгүйгээр аялал, зугаалгаар явах; 29.1.8.байгалийн ойгоос зулзаган модыг түймрээс хамгаалах халз зурвас, эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас гаргахаар төлөвлөсөн болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордтой давхацсан ойн сангийн талбайгаас аймаг, нийслэлийн байгаль орчны газрын зөвшөөрснөөс бусад тохиолдолд шилжүүлэн суулгах; 29.1.9.барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах; 29.1.10.ойн сангийн газарт улсын тусгай хэрэгцээний болон ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхээс бусад зориулалтаар барилга байгууламж барих, аливаа объект байрлуулах;

	29.1.11.мод, сөөг нутагшуулах, тарималжуулахаар хийж байгаа туршилт, судалгааны ажлаас бусад тохиолдолд мод, сөөгийн тарьц, суулгац импортлох. **30 дугаар зүйл.Ойг нөхөн сэргээх, үржүүлэх** 30.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, түүнчлэн мод бэлтгэсэн талбайн ойг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг улсын захиалгаар улсын болон орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, дотоод, гадаадын хандив, тусламжаар гүйцэтгэнэ. 30.2.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө. 30.3.Тал хээр, говь, цөлийн бүсийг ойжуулах, гол, горхи, булаг, шандын эх, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ногоон зурвас байгуулах хөтөлбөр, төслийг улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. 30.4.Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаас багагүй байна. 30.5.Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 30.6.Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. **30^1 дүгээр зүйл.Үржлийн материал бэлтгэх** 30^1.1.Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн ажилд тухайн ойн үрийн мужлалаас гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан үрийг ашиглана. 30^1.2.Ойн үрийн мужлалын хилийн заагийг ойн шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно. 30^1.3.Байгалийн гамшгийн улмаас үр нөөцөлж чадаагүй, эсхүл үрийн бага ургацын жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор удамшлын болон тарилтын сайн чанарын үрээр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр ойн үрийн улсын нөөцийн санг бүрдүүлнэ. 30^1.4.Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 30^1.5.Итгэмжлэгдсэн лаборатори ойн үрийн улсын нөөцийн санд нийлүүлэх болон худалдан борлуулах ойн үрийн шинжилгээ хийж, чанарын гэрчилгээг олгоно. 30^1.6.Гарал үүслийн болон чанарын гэрчилгээтэй үржлийн материалыг худалдан борлуулна. 30^1.7.Гарал үүсэл нь тодорхойгүй, эсхүл итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй болох нь тогтоогдсон үрийг худалдах, импортлохыг хориглоно. 30^1.8.Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. **31 дүгээр зүйл.Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах** 31.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.

	31.2.Сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна. 31.3.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын тарьж ургуулсан модыг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу худалдан авч болно. 31.4.Хот, сууриныг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах ажлыг холбогдох хуулиар зохицуулна.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтийн ерөнхий байдал? - Ой хээрийн түймэртэй тэмцэхэд учирч байгаа бэрхшээл? - Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд учир буй бэрхшээл? - Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлын үр дүн? - Ойжуулалтын үр дүн, тулгарч буй бэрхшээл? - Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээл?

- *Ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтийн ерөнхий байдал?*

Ойг хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, ой, хээрийн түймэртэй тэмцэх асуудлыг Онцгой байдлын ерөнхий газар тус тус хариуцан ажиллаж байна.

Ойг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг 43 ойн анги болон аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэдэх 8 ойн алба орон нутагт хариуцан ажиллаж байна. 2020 оны байдлаар 1342 ойн нөхөрлөл 4541.9 мян.га, 131 аж ахуйн нэгж 627.4 мян.га ойн санг тус тус гэрээгээр эзэмшиж, ашиглан хамгаалж байна.[14] Орон нутагт ойн ангиуд байгуулагдаж, ойн аж ахуйн арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулах удирдлагын тогтолцоо бий болсон ч ойн ангиудыг чадавхжуулах, материаллаг баазыг бэхжүүлэх шаардлагатай байна.

- *Ой хээрийн түймэртэй тэмцэхэд учирч байгаа бэрхшээл?*

Улсын хэмжээнд учирсан ой, хээрийн түймрийн тоо[15]

[14] Байгаль орчны төлөв байдлын тайлан 2019-2020 он, 104-р тал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2021 он
[15] Статистикийн мэдээллийн нэгдсэн - www.1212.mn



2000-2020 оны хугацаанд улсын хэмжээнд нийт жилд дунджаар 122 ой, хээрийн түймэр бүртгэгдсэн байна. Ой, хээрийн түймэрт хүний буруутай үйл ажиллагаанаас гадна хур тунадасны хэмжээ, хуурайшилт зэрэг олон хүчин зүйлээс нөлөөлж байна.

2019-2020 онд түймрийн улмаас 24.9 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирч, түймрийг унтраахад 548.5 сая төгрөгийн зардал гарсан байна. Түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 16 ойн ангид ОХУ-д үйлдвэрлэсэн фургон автомашин, үлээгч аппарат, үүргийн гал унтраагч, усны резинен сав зэрэг техник, багаж хэрэгслийг олгож ойн ангийн чадавхыг нэмэгдүүлжээ. Мөн түүнчлэн Сэлэнгэ, Увс, Дорнод, Хэнтий, Завхан, Сүхбаатар аймгуудад улсын болон орон нутгийн санхүүжилтээр 10-40 м өргөн, 1334.9 км түймрээс хамгаалах шороон зурвас байгуулсан.[16]

ОтХ-ийн 26.1-д ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ гэж заасан. Судалгааны явцад ойн нөхөрлөлүүдийн 50 гаруй хувь нь бүх гишүүд ойн түймэртэй тэмцэх ажилд бүрэн оролцдог, 30 гаруй хувь тэдгээрийн гишүүдийн 60-аас доошгүй хувь нь оролцдог гэж хариулсан. Мөн гал унтраах багаж, хэрэгслийн хувьд 60 гаруй хувь нь бэлтгэл хангасан гэж хариулсан. Эндээс үзэхэд ойн нөхөрлөлүүд ой, хээрийн түймэртэй тэмцэх ажилд өөрсдийн нөөц бололцоог ашиглаж байгаа боловч багаж, хэрэгслийн хангалт, бэлтгэлийн түвшин хангалтгүй байна.

ОтХ-д ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг ойн нөхөрлөл өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ гэж, ойн түймэртэй тэмцэхэд ямар ч урамшуулал байхгүй байгаа нь үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд нь саад тотгор үүсгэж байна. Ойн нөхөрлөл нь тухайн орон нутагт оршин сууж байгаа иргэдийн сайн дурын нэгдэл дээр бий болж ажилладаг тул

[16] Байгаль орчны төлөв байдлын тайлан 2019-2020 он, 106-р тал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2021 он

санхүү, техник, хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал байдаг. Иймд хязгаарлагдмал чадамжтай этгээдэд ойн түймрээс хамгаалах чиг үүргийг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх үүрэг хүлээлгэж байгаа нь ойн нөхөрлөлүүдийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй байна.

- *Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд учир бүй бэрхшээл?*

Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд 185.0 мян.га талбайд гүйцэтгэсэн нь ойн хөнөөлт шавжийн голомттой буюу зайлшгүй тэмцлийн ажил гүйцэтгэх талбайн 25,3 хувийг хамарч байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд ойн хөнөөлт шавжийн голомттой талбай нэмэгдэж өсөх хандлагатай байгаа учир тэмцлийн ажил гүйцэтгэх арга хэмжээг нэмэгдүүлж, цаг алдалгүй ой хамгааллын арга хэмжээг гүйцэтгэх шаардлагатай байна.

2019-2020 онуудад ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд улсын төсвөөс 1 тэрбум төгрөг, 2021 онд 810 сая төгрөг, 2022 онд 656,6 сая төгрөг, 2023 онд 7,3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

- *Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлын үр дүн?*

Хууль бус мод бэлтгэлд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/76 дугаар тушаалаар “Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ” шинэчлэн батлажээ. Ингэснээр 1м.куб модны үнэлгээг 2.7 дахин, 1 га ойн үнэлгээг 3 дахин нэмэгдүүлсэн байна.

Хууль бусаар бэлтгэгдэж хураагдсан мод 2007 онд 12941.7 м.куб байсан бол 2021 оны байдлаар 361.7 м.куб болж, бүртгэгдсэн хэрэг, зөрчлийн тоос 2007 онд 809 байсан бол 2021 онд 460 болж тус тус буурсан байна. Дурдсан 2007 онд тоног төхөөрөмж, моторт болон тавцантай хөрөө 60 ширхгийг улсын орлого болгож байсан бол 2021 оны байдлаар 3 болж буурчээ. Эндээс үзэхэд хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд тодорхой ахиц гарсан байна. Цаашид модны хангамжийг нэмэгдүүлэх, ойн нөөц бүхий сумдад модны нэгдсэн захууд байгуулах зэргээр мод, модон материалын эрэлт, нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээг авах, хууль зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог урамшуулах зэрэг арга механизмыг хэрэглэх замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох шаардлагатай.

- *Ойжуулалтын үр дүн, тулгарч бүй бэрхшээл?*

Улсын хэмжээнд 2019 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 2392,5 га талбайд, байгалийн сэргэн ургалтад

туслах ажлыг 4683,5 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 1878,1 га талбайд хийж, ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 8954.1 га талбайд хийсэн бол 2020 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 3088,7 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 582 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 371.5 га талбайд хийж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 4042,2 га талбайд хийжээ.

Арга хэмжээ	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Үр бэлтгэх талбай, га	20	25	25	50	50	-	50	985.9	990.3	989.9
Үрийн нөөц, кг	550	322,5	335,6	421,1	612	477	460	314	175,5	64,5
Тарьц, сая.шир	36.0	32.9	40.1	46,9	46.3	30,0	34,6	34.6	38,9	41,6
Ойжуулалт, га	7989	6417	6403	5850	5240	3163	2381,6	3221,8	2392,5	3088,7
Ойн зурвас, га	595,5	856	857	399	392,7	172	223,5	345,9	1878,1	371.5
Байгалийн сэргэн ургалтад туслах, га	2342	1126	810	40	85	100	1067,0	2459,9	4683,5	582.0
Нийт	10926,5	8399	8070	6289	5717,7	3435,0	3672,1	6027,6	8954,1	4042,2

Жил бүр явуулдаг ой зохион байгуулалтын судалгааны үр дүнгээс харахад 1990, 2000 оны эхэн үеийн их түймэрт нэрвэгдсэн ойгоос 1.0 сая.га орчим нь байгалийн аясаараа сэргэн ургаж байгаа бөгөөд дахиж түймэр, хөнөөлт шавжид өртүүлэхгүй байх, гэрэлжүүлэх, тохируулах хэлбэрийн арчилгааны огтлолтыг явуулж, өсөлтийг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлбэл ойгоор бүрхэгдсэн талбайд шилжих бүрэн боломжтой байна. Харин сэргэн ургалт хангалтгүй байгаа 462.5 мян.га талбайд тарьц, суулгацаар зориудаар ойжуулах, өсвөр модыг хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай байгаа боловч улсын болон орон нутгийн төсөв хүрэлцэхгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар, “Хот орчныг цэцэрлэгжүүлэх тухай” 2013 оны 178 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд 2019-2020 онд 6777 аж ахуйн нэгж байгууллага, 223947 иргэд 1675159 ширхэг мод, сөөгийг 136,8 га талбайд тарьж, ногоон байгууламжийн талбайг 31,8 га-аар нэмэгдүүлсэн байна. Бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт иргэд маш идэвхтэй оролцдог уламжлалт арга хэмжээ болж хэвшиж байгаа боловч тарьсан мод, сөөгт байнгын арчилгаа, хамгаалалт хийгддэггүйгээс мод, сөөгийн ургалт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай.

- *<u>Ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээл?</u>*

Ойн тухай хуулийн 3.1.6-д “ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл шат шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж ойн менежментийн төлөвлөгөөтэй байхаар зохицуулсан боловч ОтХ-д хуульд шат шатны ойн менежментийн төлөвлөгөө хоорондоо хэрхэн уялдах нь тодорхой бус байгаагаас ойн менежментийн төлөвлөгөөг цогц байдлаар хэрэгжүүлэх боломжгүй байна.

Улсын ойн менежментийн төлөвлөгөө нь түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төлөвлөх, батлах, зарцуулахтай уялдахгүй байна. Учир нь улсын ойн менежментийн төлөвлөгөөний төслийг Ойн агентлаг боловсруулж[17], яам баталж, ойн менежментийн төлөвлөгөөг яам хэрэгжүүлж[18] байгаа боловч түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх чиг үүргийг

[17] ОтХ-ийн 14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих,
[18] ОтХ-ийн 13.1.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих

Ойн агентлагт[19] олгосон байна. Өөрөөр хэлбэл Ойн агентлаг улсын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах чиг үүрэг нь Төсвийн тухай хууль болон орон нутгийн өөрөө удирдах ёсны чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

Мөн түүнчлэн Ойн тухай хуульд аймаг, нийслэл ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах болон хэрэгжилтийг хангах этгээд нь тодорхой бус байгаагаас аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Ойн тухай хуулийн 14.3.2-т зааснаар Ойн агентлагт аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах бүрэн олгогдсон боловч Ойн тухай хуулийн 17.1-т Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд, 17.2-т Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, шаардагдах төсвийг батлах асуудал огт тусгагдаагүй байна. Харин тус хуулийн 17.1.1-т Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал <u>ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах</u> арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих эрхтэй гэж, мөн хуулийн 17.2.2-т Аймаг, нийслэлийн Засаг дарга <u>ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга</u> хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах бүрэн эрхтэй гэж тус тус заасан. Эндээс үзэхэд аймаг, нийслэл ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах төсвийг батлах, хэрэгжүүлэх этгээд нь тодорхой бус байна. Энэ байдал сумын түвшинд мөн адил давтагдаж байна.

2.6. ОЙГ АШИГЛАХ

Үнэлэх хэсэг	**32 дугаар зүйл.Бэлтгэж ашиглах модны хэмжээг тогтоох** 32.1.Ойгоос тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно. 32.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг энэ хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно. 32.3.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөө болон иргэдийн хэрэгцээг үндэслэн энэ хуулийн 35.1, 35.2 дахь хэсэгт заасны дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг дараах байдлаар тогтооно: **38 дугаар зүйл. Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим** 38.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн ойн анги /байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч/ олгоно.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Ойгоос бэлтгэж ашиглах модны хэмжээг ойн тогтвортой менежментийг хангах зорилтын хүрээнд мэргэжлийн олгож байгаа эсэх? - Ойн мэргэжлийн ? - Ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг олгохтой холбоотой зохицуулалт нь бусад хууль тогтоомжтой уялдаж байгаа эсэх? - Ойн дагалт баялаг ашиглах горим нь мод, бут, сөөг гэмтээхгүй, устгахгүй байх зохицуулалтыг агуулж байгаа эсэх

[19] ОтХ-ийн14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих

Ойн тухай хуульд ойн нөөцийн тогтвортой бөгөөд зохистой ашиглалтыг дэмжсэн эрх зүйн зохицуулалт тусгагдсан эсэх.

Өнөөгийн хуулийн зохицуулалтын дагуу ойн нөөц ашиглах буюу мод бэлтгэх хэмжээг БОАЖЯ нь аймаг, нийслэлээр жил бүр тогтооно. Энэ хэмжээнд багтаан аймаг, нийслэлийн ИТХ нь сум, дүүргээр, сум дүүргийн ИТХ нь хуульд заасны дагуу тогтоодог. Жилд ашигласан ойн нөөцийн хэмжээг Үндэсний статистикийн хорооны мэдээллээс харуулбал,

Жилд бэлтгэх модны квот тогтоох үйл явц нь дээд хэсэгтээ салбар хариуцсан мэргэжлийн яамны оролцоотой байх бол орон нутгийн түвшинд захиргааны болон улс төрийн институцийн асар их оролцоотой улс төрийн шинжтэй шийдвэр гаргах үйл явц болж хувирсан байна. Ойн нөөц бэлтгэх хэмжээ тогтооход дээр дурдсанаар улс төр, төрийн захиргаа, сум орон нутгийн зэрэг олон тооны оролцогч талуудтай байхын зэрэгцээ квот тогтоохдоо юуг үндэслэх буюу ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл болсон ойн менежментийн төлөвлөгөөг огт тусгаагүй байгааг өөрчилж, тухайн жилд бэлтгэх модны нөөцийн хэмжээг зөвхөн ойн менежментийн төлөвлөгөөг харгалзан тогтоодог болох нь зүйтэй. Энэ тохиолдолд улс төрийн болон бусад ашиг сонирхлын шинжтэй шийдвэр гаргах орон зай хумигдаж, модыг зөвхөн нөөцийн хэмжээ, ашиглалтын горим зэрэг хүнээс хамааралгүй хүчин зүйлсэд тулгуурлан ашигладаг болох суурь тавигдана.

<u>Ойн тухай хуулийн өнөөгийн зохицуулалтаар ойн дагалт баялгийн зохистой ашиглалтыг дэмжсэн хууль зүйн зохицуулалт бүрдсэн эсэх?</u>

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-т зааснаар сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг ойн дагалт баялагт тооцдог. Ойн дагалт баялгийн нөөцийг зохистой хэмжээгээр түүж бэлтгэх, ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах, худалдан борлуулах зэрэг нь иргэдийн аж амьдрал, эдийн засгийн нөхцөл байдалд төдийгүй улс орны эдийн засагт ч эерэг нөлөөлөл үзүүлдэг.

Эдгээрийн ойгоос нийтлэг байдлаар авч ашигладаг нь сибирь хуш модны үр буюу самар. Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацын жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө гэж ОтХ-д заасан боловч ургацыг хэрхэн тодорхойлох талаар өөрөөр заасан зүйл хуульд тусгагдаагүй.

Монгол орны нийт ойн нөөц 1.248.42.118 шоо метр байгаа бөгөөд үүнээс ойн нөөцийн 79.2 хувийг шинэс, 8.9 хувийг хуш эзэлнэ. Хушин ой нь дэлхийд байх тархац маш бага /35 сая га/ гэдэг утгаараа Монгол орны ховор ургамлын төрөл, зүйлд хамаардаг.[20] Түүнчлэн хушин ой нь 70 орчим зүйлийн хөхтөн, 200 орчим зүйл шувуудын идэш тэжээлийн нөөцийг бүрдүүлдэг бөгөөд хур, сойр, самарч шаазгай, хөтүү зэрэг шувууд, жирх, хэрэм зэрэг мэрэгчид; баавгай, гахай зэрэг зэрлэг амьтдын гол хүнс тэжээл юм.[21] Ийм учир хушин

[20] Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол.
[21] Хушны самрыг зүй зохистой түүж бэлтгэх, ашиглах гарын авлага. Б.Удвал. Улаанбаатар: 2020.

ойн самрын нөөцийн 70 хувийг байгальд нь үлдээгээд, 30 хувийг нь түүхэд хушин ойн байгаль экологийн тэнцвэрийг хадгалах, нөхөн сэргэхэд нь онц харшлахгүй гэсэн дүгнэлтийг эрдэмтэд хийсэн байдаг.

Гэтэл хуш модны самар бэлтгэл, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хушин ойн тархац хурдацтай багасахын хажуугаар ойн сэргэн ургалт маш бага явагдаж байгааг судлаачдын судалгаа дүгнэлтээр харагдаж байна. Хамгийн сүүлд хийгдсэн Д.Цэндсүрэн (2021) нарын хийсэн "Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн дагалт баялгийн судалгаа" - наас харахад хотын ногоон бүсийн хушин ойн 60 хувь нь өсөлт саарч буй, 30 гаруй хувь нь өсөлт зогссон бөгөөд сүүлийн 20 жилд хуш модны жилийн цагаригийн өсөлт буурсан үр дүнг харуулжээ[22]

Иймд ойн дагалт баялгийн нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, ойн дагалт баялаг байгалийн жамаараа нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний тулд ойн дагалт баялгийн нөөцийг биологийн буюу байгаль дээр байх бодит нөөц, ашиглах нөөц буюу тухайн жилд түүж бэлтгэх хэмжээг тооцдог аргачлал, шалгуур үзүүлэлт гаргах, эдгээрийн дагуу тодорхойлж тогтоосон хэмжээнд дагалт баялгийн нөөцийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

- *Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт ойн дагалт баялгийг эрхийн бичгээр олгохоор заасан нь бусад хууль тогтоомжтой уялдан хэрэгжих боломжтой эсэх*

Хуулийн дээрх хэсэгт дурдсанаар ойн дагалт баялгийг ойн анги, байхгүй бол байгаль хамгаалагч шууд олгохоор заасан. Улсын Их Хурлаас Зөвшөөрлийн тухай хуулийг 2022 онд батлан гаргаж, үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоох зэрэг харилцааг нэгдмэл байдлаар зохицуулах болсон.

Ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичиг нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1.1-д зааснаар зөвшөөрөлд тооцогдох бөгөөд мөн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 1.29-д зааснаар ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулах тохиолдолд дуудлага худалдааны журмаар олгогдох зохицуулалттай. Мөн хуулийн 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичгийг зөвхөн дуудлага худалдааны журмаар олгох ёстой бөгөөд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг тухайлсан хууль буюу Ойн тухай хуулиар зохицуулах ёстой.

Гэтэл Ойн тухай хуулийн 38 дугаар зүйлд ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн ойн анги (байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч) олгохоор ерөнхий зохицуулсан байх бөгөөд энэ нь Зөвшөөрлийн хуулийн дээрх зохицуулалттай шууд зөрчилдөхөөр нөхцөл байдлыг үүсгэжээ.

Иймд Ойн тухай хуульд ойн дагалт баялгийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулах эрхийн бичгийг олгох зохицуулалтыг ялгамжтай тусгах, үйлдвэрлэлийн зориулалтаар эрхийн бичиг олгох дуудлага худалдаа явуулах журмыг хуульчилж тогтоох шаардлагатай.

- *<u>Хуулийн 38 дугаар зүйлд ойн дагалт баялаг ашиглахтай холбоотой дэглэмийг зохицуулахдаа мод гэмтээхгүй байх, хамгаалах талаарх зохицуулалт тусгагдсан эсэх</u>*

[22] Д.Цэндсүрэн. Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн дагалт баялгийн судалгаа. Улаанбаатар хот : 2021.

Ойн тухай хуульд ойн дагалт баялаг ашиглахдаа мод, бут, сөөг гэмтээхгүй байх арга технологи ашиглах талаар тухайлсан зохицуулалт алга байна. Дээр дурдсанаар манай орны хувьд ялангуяа хушин ойн нөөц тодорхой хязгаартайн зэрэгцээ түймэр, зохисгүй ашиглалт, байгаль, цаг уурын өөрчлөлт, дулаарлын нөлөөгөөр багасах байдал ажиглагдаж байна.

Үүнээс гадна манай орны нөхцөлд иргэд, аж ахуйн нэгж самар түүхдээ модны ишийг доргиох замаар боргоцойг түүх аргыг өргөн ашигладаг бөгөөд үүнийг “мунадах” гэж ярьдаг. Самар түүх зорилгоор мунаар цохисон модны холтос халцарч хамгийн түрүүн холтосны дор байх модлог эд ил гарч, модны хоёрдогч өсөлтийг бүрэлдүүлэгч золом (cambium) үе давхарга механик гэмтэлд өртдөг.

Өнөөгийн байдлаар хэдий ч хэмжээний хушин ой ийм зохисгүй арга технологи ашигласны улмаас гэмтсэн, устсан талаарх тодорхой тоо баримт, судалгаа тооцоо байхгүй боловч үүнийг хуульд тусгайлан зааж хориглох гарцаагүй шаардлага үүсэж буй юм.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, судалсан судалгааны үр дүнд дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл

- Ойн тухай хуулийн 4.2-т Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно гэж заасан боловч өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд ой модыг өмчилсөн тохиолдолд байхгүй байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байна. Тодруулбал, “ой мод”-ны тухай тодорхойлолт ОтХ-д тодорхой тусгагдаагүй, “ой”-оос юугаараа ялгаатай болох нь тодорхой биш байна. Мөн ой модны доорх газрын харилцааг ОтХ, Газрын тухай хууль тогтоомжуудад зохицуулаагүй байгаа тул хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдал үүссэн байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 1-т Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна, мөн зүйлийн 2-т Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гэж тус тус заасан тул ойг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх тухай зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчил үүсгэж байна. Иймд Ойг өмчлөх харилцааг Үндсэн хууль, Газрын тухай хуультай нийцэх эсэхийг эргэн авч үзэхийг зөвлөж байна.

- Ойн тухай хуулийн 4.13-т Энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно /ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардал/ гэж заасан боловч энэ журам одоогоор батлагдаагүй байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай хэрхэн уялдах нь тодорхойгүй байгаатай холбоотой байна. БНАТтХ-ийн 1-р зүйлд тус хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна гэж заасан. Тус хуулийн 18.1-т зааснаар ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна гэж заасан тул хууль хоорондын уялдаа тодорхойгүй, давхардсан байдал үүсжээ.

- Ойн тухай хуулийн 6.1-т Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн,

үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна гэж заажээ. ОтХ-ийн 6.1-т заасан ойн мэдээллийн санг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р бүлэгт заасан Байгаль орчны мэдээллийн сангийн бүрдэл болох нь тодорхой байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн эрхлэн хөтөлж байна.

Ойн тухай хуулийн 6.2-т "Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заажээ. Энд заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 02 сарын 19-ны өдрийн А-53 тоот тушаалаар "Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх тухай журам"-ыг баталсан байна. Гэвч тус журмын 2.4-т "мэдээллийн сангийн мэдээ бүрдүүлэх, боловсруулах, түгээх программ хангамжийг хөгжүүлэх, ажиллах горимыг зохицуулах, шуурхай байдал, хамгаалалт, нууцлалтын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг Байгаль орчны мэдээллийн төв хариуцан ажиллана" гэж, 2.5-т "Мэдээллийн сангийн мэдээг бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, ашиглах, түгээх, хадгалах, баяжуулах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал, зөвлөмж гаргах, хэрэглэгчдэд нээлттэй болон төлбөртэй мэдээллийн жагсаалт гаргах, мэдээллийн үнэн зөв байдал, чанар, анхдагч боловсруулалтыг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хариуцна тус тус заасан. Засгийн газрын 2022 оны 7-р сарын 5-ны өдрийн 272-р тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ойн газрыг байгуулахаар шийдвэрлэсэн боловч шинээр байгуулагдсан Ойн газар ойн мэдээллийн сан бүрдүүлэхэд ямар чиг үүрэгтэй оролцох нь тодорхойгүй байсаар байна.

"Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх тухай журам"-ын дагуу ойн анги нь мэдээллийн сангийн бүртгэл, тайланг хариуцан гүйцэтгэнэ гэж заасан боловч зарим ойн анги мэдээллийн сангийн талаарх мэдээлэл дутмаг байна.

Иймд Ойн мэдээллийн санг бүрдүүлэгч нарт ойн мэдээллийн сангийн талаарх мэдээллийг тогтмол хүргэх, мэдээлэл бүрдүүлэх үүргийг хариуцлагажуулах, тус харилцаанд Ойн агентлагийн чиг үүргийг тодорхой болгох, Ойн мэдээллийн санд ойн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг мэдээг тусгахыг зөвлөж байна.

2. Ойн бүс, тэдгээрийн хамгаалалтын дэглэм

- Ойн тухай хуулийн 8.1-д зааснаар хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна гэж, 8.3-т цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно гэж, 8.5.1-д нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар тус тус тогтооно гэж заасан.

  2021 оны байдлаар Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл аймгууд цармын бүслүүрийн ойн заагийг тогтоосон байгаа бөгөөд нийт 39,136 га талбай үүнд хамаарч байна.[23] Нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газрын 1996 оны 326-р тогтоолын хавсралтаар тогтоосон байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн ногоон бүсийн ойд 887,538 га газар[24] хамаарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан. Улсын хэмжээнд 107 ТХГ[25]

[23] Монгол Улсын ойн сан, 14-р хавсралт, Ойн судалгаа, хөгжлийн төв, 2021 он
[24] Монгол Улсын ойн сан, 14-р хавсралт, Ойн судалгаа, хөгжлийн төв, 2021 он
[25] https://www.eic.mn/spa/

байгаа бөгөөд улсын тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ 21927.0 мянган гад хүрчээ. Нийт дүнгээр авч үзвэл хамгаалалтын бүсийн ойд 7,611,537 га газар хамаарч байгаа бөгөөд энэ нь нийт ойн сангийн 83,1 хувийг хамаарч байна.

- Ойн тухай хуулийн 8.6-д хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно, 9.2-т Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын бүсийн ойгоос мод, ойн дагалт баялгийг зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглах эрхтэй гэж тус тус заасан. Тусгай хамгаалалттай газрын хувьд тусгайлсан хуультай, тухайн хуулиар нь хамгаалалтын газрын захиргаа байгуулагдаж, чиг үүрэг нь тодорхой тусгагдсан тул хамгаалалтын дэглэм тодорхой хэмжээнд хэрэгжиж байна. Харин бусад хамгаалалтын бүсийн ойд хамгаалалтын дэглэм хангалтгүй хэрэгжиж байна. Учир нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмагаас гадна хамгаалалтын бүсийн ойг хариуцах этгээд тодорхой биш, байгаль хамгаалагчийн хүрэлцээ, техник, хангамж муу байгаатай холбоотой байна.

  Байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд “Ойн тухай” хууль зөрчсөн зөрчил 2004 онд 36.8 хувийг эзэлж байсан бол 2022 онд 10 хувь болж буурсан байна. ОтХ-ийн бүртгэгдсэн хэрэг, зөрчил 2011 онд 1246 байсан бол 2021 онд 460 болон буурсан байна

- Монгол Улс өнгөрсөн хугацаанд ойг хамгаалах бодлогыг түлхүү хэрэгжүүлж ирсэн байна. Энэхүү бодлогын хүрээнд ойн нөөц ашиглалтыг жил бүр ойгоос бэлтгэх модны квот тогтоох, ойн нөхөрлөлд зөвхөн унасан мод түүх, огтлох, ойн сангийн тодорхой хэсгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт тооцож ой мод огтлохыг хязгаарлах замаар хэрэгжүүлжээ. Өнөөдрийн байдлаар ойн сангийн 15471.5 мян.га буюу 83.1% нь хамгаалалтын бүсийн, 3136.5 мян.га буюу 16.9% нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна. Ойг хамгаалах бодлогыг дангаар нь хэрэгжүүлснээр ой сангийн нөөцийн 76 хувь нь болц гүйцсэн буюу хөгширсөн, унанги болон ойн хөнөөлт шавжид идэгдсэн ойн талбай ихээр нэмэгдсэнээр ойн цэвэрлэгээний зардал үлэмж нэмэгдсэн, залуу мод ургах буюу ойн байгалийн нөхөн сэргээлт явагдах нөхцөл багассан, ойн эдийн засгийн бүтээмж буурсан, ойг эдийн засгийн эргэлтэд оруулахыг хязгаарласнаас ойн анги, ойн мэргэжлийн байгууллагууд бие даагаагүй, зөвхөн төсвийн хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай болсон зэрэг сөрөг үр дагаврууд үүссэн байна.

  Иймд ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөнд үндэслэн ойг зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх замаар ойг эдийн засгийн эргэлтэнд оруулахыг зөвлөж байна.

3. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

- Бодлогын түвшинд төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний харьяа ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажилладаг. Эдгээр нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн хээрийг түймрээс хамгаалах, байгаль орчны тэнцлийг хангах талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх холбогдох дүрэм, журам, стандартыг батлах, биелэлтийг хангуулах, ойн аж ахуйн арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зэрэг улсын хэмжээнд ойн салбарын удирдлага, зохион байгуулалт, төрийн бодлого, хууль тогтоомжийг хангуулах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлдэг. Гүйцэтгэлийн түвшний буюу эдгээр төрийн бодлого, хууль тогтоомжийг практикт хэрэгжүүлэх чиг үүрэг нь аймаг, нийслэлийн БОАЖГ болон ойн ангиудад харьяалагддаг. Бодлогын түвшний байгууллагууд нь босоо буюу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд байдаг бол гүйцэтгэлийн түвшний байгууллагууд нь орон нутагт

харьяалагддаг. ОтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.2.8, 18 дугаар зүйлийн 18.2.9-д тус тус зааснаар сум дундын болон сумын ойн ангийг төсвийг тухайн шатны ИТХ баталж, даргыг нь мөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлж байна. Ойн салбарын удирдлагын тогтолцооны энэхүү нөхцөл байдлаас улбаалж, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн ойг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажилд үр дүнгүй болоход хүргэхүйц дараах асуудал тулгамдаж байна.
Нэгд, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа холбооны хувьд хангалтгүй байна. Аймгийн түвшинд байгаль орчин, аялал жуулчлалын газарт цөөн тооны ойн хэлтэс, газар, мэргэжилтэн ажилладаг. Сум орон нутгийн түвшинд ойн ангиуд нь ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагыг хариуцан ажилладаг. Энэ дагуу ойн асуудлаар гарсан бодлогын шийдвэр, арга хэмжээг эхлээд орон нутагт Засаг дарга, дараа нь түүний харьяа байгаль орчин, аялал жуулчлалын газарт, эцэст нь ойн ангийн дарга нарт хүргүүлсний эцэст хэрэгждэг нь цаг хугацаа, шат дамжлага ихтэй процесс байна.

Хоёрт, ойн салбарын улс төрийн хамаарлыг багасгах шаардлага тулгарсан байна. Аймаг, сумын Засаг дарга нь төрийн улс төрийн албан тушаалтан бөгөөд дөрвөн жил тутам болдог улс төрийн сонгуулийн үр дүнгээр томилогддог. Ойн салбарын бодлогыг хээрийн түвшинд гардан хэрэгжүүлж буй ойн ангийн удирдлагыг дээрх хуулийн зохицуулалтад зааснаар улс төрийн албан тушаалтан томилж, чөлөөлөх, ажлыг нь үнэлж дүгнэх эрх хэмжээтэй байгаа нь ойн салбарын тогтвортой менежмент анхан шатанд хэрэгжихэд хүндрэл учруулж байж болзошгүй юм. Тодруулбал, улс төрийн сонгуулиас хойш дөрвөн жилийн дотор сум дундын ойн ангийн дарга нар тогтмол солигдож байгаа нь ТА9899 төслийн явцад хийсэн хэлэлцүүлэг, үнэлгээнээс харагдаж байна. Судалгааны явцад 36 ойн ангийн дарга, инженер зэрэг 43 албан хаагчтай ярилцлага хийсэн бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ямар нэг саад бэрхшээл тулгардаг эсэхийг асуухад ихэнх нь улс төрийн намын сонгуулийн дөрвөн жил тутамд төрийн албанд тодорхой хэмжээний халаа сэлгээ хийдэг байдал нь гол саад бэрхшээл учруулдаг гэж мэдэгдсэн байна. Тодруулбал, сум дундын ойн ангийн даргыг мэргэжлийн бус хүмүүсээр байнга сольж хольж байдаг бөгөөд ойн инженерүүд ажлаа эхнээс нь даргадаа тайлбарлаж богино хугацаанд ажлаа ойлгуулж явуулах процесс нь ихээхэн хүндрэл учруулдаг. Түүнчлэн дарга солигдсоны дараа ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа дуусаагүй байсан ч төлөвлөсөн ажил өөрчлөгдөх байдал ажиглагддаг байна. Түүнчлэн ойн анги, ойн байгууллагуудын дарга нар эсхүл орон нутгийн засаг захиргааны дарамт, хууль бус үйлдлийг таслан зогсоох гэхэд сум дундын ойн ангийн албан хаагчдын эрх хэмжээ дутмаг байх явдал, орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлэхгүй байх явдал, ажлын байрны тогтворгүй байдал зэрэг нь тулгамдсан асуудал болдог талаар дурджээ.

Гуравт, ойн салбарын удирдлагын нэгдмэл байдал бүрдэж чадаагүй байгаа нь хээрийн түвшинд ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэгч гол субьект болсон ойн ангиудын чадавх суларч, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, төсөв санхүүгийн хувьд чадавхжиж чадахгүй байгаа нь ойн салбарын хөгжилд саад болж буй нэг хүчин зүйл болжээ. Зөвхөн санхүүгийн чадавхын тулгамдсан асуудлыг авч үзвэл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн төслийг ойн ангиас орон нутгийн Засаг дарга, дараа нь Ойн хэлтэс, дараа нь аймгийн Засаг дарга, дараа нь яаманд шилжиж ирсэн үед төсөв боловсруулдаг. Сангийн яам ихэвчлэн төсвийн саналын талыг нь хасдаг ба эцэст нь маш их танаж, хассан төсвийн үлдэгдэл ойн ангид ирдэг. Ихэнх тохиолдолд энэ нь 6 орон тооны зөвхөн 3 орон тоог нь цалинжуулах боломжтой төсөв батлагддаг бөгөөд үлдсэнийг нь ойн анги өөрсдийн орлого, орон нутгийн засаг захиргаа эсвэл зарим тохиолдолд орон нутгийн компани эсхүл төслөөс тодорхой хэмжээний санхүүжилт авч аргацаасан байдлаар цалинжуулж байна.

Иймд ой ургах орчин нөхцөлийг сайжруулах, ойжуулсан талбайг хамгаалах, арчилгаа цэвэрлэгээ болон нөхөн сэргээсэн талбайд мод бэлтгэл явуулах

үлгэрчилсэн талбайн загвар бий болгох, дэд бүтцийг сайжруулах, ойн түймэр, хортон шавжийн хор хөнөөл, аюулыг бууруулахын тулд ойд эргээд хөрөнгө оруулалт хийхийг зөвлөж байна.

- Ойн аж ахуйн асуудлыг хариуцах босоо бүтэцтэй, чадалтай захиргаатай болох шаардлагатай байна. Ойн газрыг шинээр байгуулсан байгуулснаар ойн салбарын байгууллагын зохион байгуулалтын үйл явц босоо бүтэцтэй болоход нэг алхам ойртсон боловч ойн салбарын бодлогын арга хэмжээг практикт буюу хээрийн түвшинд хэрэгжүүлэх бүтэц байхгүй хэвээр байна. Иймд хууль тогтоомж, БОАЖЯ, Ойн газрын шийдвэрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ойн ангиудын удирдлагыг орон нутгийн харьяаллаас гаргаж, босоо бүтэцтэй болгох шаардлагатай.

4. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

- Ойг хамгаалах, зохистой ашиглах үйл явцад ойн нөхөрлөлийн гүйцэтгэх үүрэг багагүй юм. Монгол Улсын хэмжээнд ойролцоогоор 1342 ойн нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нөхөрлөлүүд дунджаар 20 гишүүнтэй бөгөөд нийт 4143 га ойн сангийн талбайг гэрээгээр эзэмшиж байна. Дээр дурдсан судалгааны хүрээнд нийт 107 нөхөрлөлөөс нэг бүрчлэн чадавхын үнэлгээ авч судалсан. Эдгээр нөхөрлөлийн 86 хувьд ойн менежментийн төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүний 92 хувь нь сумын ИТХ-аар батлуулжээ. Эдгээрээс ойн менежментийн төлөвлөгөөг ойн мэргэжлийн байгууллагаар 58, ойн ангиар 31 хийлгэсэн бол бусад нь өөр байгууллагаар хийлгэсэн бөгөөд ийнхүү мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь төсөв санхүүгийн хувьд зардалтайгаас гадна өөрсдийн үйл ажиллагаанд нь төдийлөн хэрэг болдоггүй, газар дээр нь ирж ажиллан хийдэггүй, бусдын төлөвлөгөөг хуулсан байхаас гадна ойн нөхөрлөлүүд мод бэлтгэх эрхгүй байхад нь бодит байдал дээр огт хэрэгжихээргүй тоонууд гаргасан байдаг аж. Уг зүй нь ойн нөхөрлөл бол ойг хариуцан хамгаалах зорилготой, мэргэжлийн бус буюу иргэд, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн сайн дурын шинжтэй байгууллага юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ОТХ-иар ойн менежментийн төлөвлөгөөтэй байхаар заасан нь тухайн хариуцаж буй ойн талбайд хэрэгжих мэргэжлийн шинжтэй үйл ажиллагааг ойн нөхөрлөлүүд хийх мэт давхардсан ойлголтыг бий болгожээ.
- Ойн нөхөрлөл нэгэнт сум орон нутагтай гэрээтэй ажилладаг тул тайлангаа тавьж хэлэлцүүлэх хуулийн зохицуулалтыг мөрдөх ёстой. Гэтэл дээр дурдсан үнэлгээнээс үзвэл нийт судалгаанд хамрагдсан 107 ойн нөхөрлөлүүдийн 45 орчим хувь нь сумынхаа ИТХ-д ажлаа жил бүр тайлагнадаг, 23 хувь нь огт тайлагнадаггүй бол 8.4 хувьд хааяа, 12.15 хувь нь заримдаа, 11.2 хувь нь ихэнхдээ танилцуулдаг гэжээ. Эндээс товч дүгнэвэл ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг тогтмол буюу жил бүр үнэлж дүгнэх механизмыг хангалттай түвшинд хэрэгжүүлэх, ойн нөхөрлөлийг үйл ажиллагааны хувьд төлөвшүүлэх шаардлага тулгамдаж байна.
- Ойн нөхөрлөлүүд түймрээс хамгаалах ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр заасан нь хэрэгжим боломж хязгаарлагдмал юм. Өмнө дурдсанаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нь төрийн чиг үүргийн олон төрлийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, ойн нөхөрлөл, иргэдийн оролцоотой хэрэгждэг ажил юм. Тухайлбал, ОтХ-ийн 18.2.10 - 18.2.14 дэх заалтад ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг тусгаж өгсөн бөгөөд ойн нөхөрлөлд өөрийн хөрөнгөөр энэ ажлыг давхар гүйцэтгэх үүргийг хүлээлгэсэн нь эрх зүйн хэм хэмжээний давхардал үүсгэж буй юм. Нөгөө талаас ойн нөхөрлөлийн хувьд зөвхөн ойн сангийн тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хариуцан хамгаалж буй иргэдийн сайн дурын нэгдэл тул эдгээр олон субъектийн өмнөөс хөрөнгө гаргаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зохимжгүй бөгөөд гаргасан тохиолдолд урамшуулал авах зохицуулалт шаардлагатай
- Ойн нөхөрлөлүүдийн санхүүгийн чадавхын байдал тааруу байна. Тайланд дурдсанаар ойн нөхөрлөлүүд нь хуулийн этгээдэд тооцогддоггүй, гэрээний үндсэн дээр бий болсон иргэдийн хамтрал хэлбэртэй бөгөөд улсын бүртгэлтэй татварын дугааргүй тул ашиг олох үйл ажиллагаа нь маш хязгаарлагдмал байна.

Нөхөрлөлийн дундын сан, орлого бий болгох үйл ажиллагаа, ой хамгаалал, нөхөн сэргээлтэд гардаг зардлыг тодруулж үзвэл судалгаанд хамрагдсан ОН-үүдийн 44% нь дундын сангүй, 22.4% нь 1 сая төгрөгөөс бага, 17% нь 3.1-10 сая төгрөг, ердөө 3% нь 10 сая төгрөгөөс дээш дундын сантай байна. Нөгөө талаас ОН-үүдийн 36 орчим хувь нь үндсэндээ орлогогүй, ердөө 7,48 хувь нь 10 сая төгрөгөөс дээш орлоготой байна. Санхүүгийн хувьд чадавх сул байгаа нь ойн тогтвортой менежментэд хувь нэмэр оруулж ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх чадавхтай нь шууд холбогдох бөгөөд иймд ойн нөхөрлөлүүдийг санхүүгийн хувьд чадавхжуулах, нүүрстөрөгчийн худалдаанд оролцох зэрэг арга механизмыг хуульд тусгах шаардлагатай.

- Нөгөө талаас сум орон нутгийн түвшинд ойн нөхөрлөлүүдийг дэмжих, хамтран ажиллаж байгаа эсэх нь тэдгээрийн үйл ажиллагаа амжилттай явагдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Сум/сум дундын ойн ангиуд ой модтой холбоотой бүхий л үйл ажиллагаануудад ОН-үүдэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажилладаг. Үүнд ОН-г шинээр байгуулах, хариуцсан ойн сангийн зураглал хийх, ойн менежментийн төлөвлөгөө гаргах, чадавхжуулах сургалтууд зохион байгуулах зэрэг ордог.
- Ойн мэргэжлийн байгууллагуудын хувьд үйл ажиллагаанд нь тулгарч буй асуудлын дийлэнх нь техник тоног төхөөрөмж хангалтгүй байдаг нь ажлын гүйцэтгэлд саад учруулдаг гэж хариулсан бөгөөд нийт хариултын 20%-ийг эзэлж байв. Түүний дараа мөн адил санхүүгийн чадавх хангалтгүй (19%), хүний нөөц хангалтгүй (17%), идэвх зүтгэл, санаачилга хангалтгүй (11%) байдал, орон нутгийн засаг захиргааны буруу шийдвэр, хариу арга хэмжээ (11%), Ойн менежментийн төлөвлөгөөний бодит бус боловсруулалт (9%), “бусад” хэмээх ангилалд дурдсан саад бэрхшээлүүд нь 7%-ийг эзэлж байсан бол БОАЖЯ-ны зохисгүй шийдвэр нь хамгийн бага хувь буюу 6%-ийг эзэлж байгаа нь СДОА-уудаас авсан судалгаанаас харагдаж байна (Зураг 5).
- Дээрх асуудлуудаас хүний нөөцийн чадавхын тулгамдсан асуудлыг эхний ээлжид авч үзвэл, судалгаанд хамрагдсан 100 аж ахуйн нэгжид нийт 1055 хүн ажилладаг бөгөөд нэг ойн мэргэжлийн байгууллага дунджаар 10 ажилтантай. (Зөвхөн Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн Төмөр замын дэр модны үйлдвэр л 144 ажилтантай бөгөөд үүнийг тооцож үзвэл дундаж ажилтны тоо 9 болж буурна) Нийт ажиллагсдын 807 /76 %/ нь эрэгтэй, 248 /24%/ нь эмэгтэй.
- Хүний нөөцийн чадавх сул байгаа нь санхүүгийн чадавхтай шууд холбоотой. Аливаа байгууллага санхүүгийн зохих чадавхтай, түүнийг зарцуулж удирддаг зөв менежменттэй байсны үндсэн дээр л хүн хүч, техник технологийн хувьд бэхэжнэ. Ойн мэргэжлийн байгууллагын санхүүжилтийн үндсэн эх үүсвэрээ ойн баялгийн ашиглалтаас олж авна. Улсын хэмжээнд ойн мэргэжлийн байгууллага сүүлийн 3 жилийн дунджаар жилд 400 м3 мод ойгоос бэлтгэж байна. Сэлэнгэ аймгийн ОМБ-уудын жилд бэлтгэдэг модны хэмжээ харьцангуй илүү, дунджаар 1000 м3-ээс дээш, Хөвсгөл аймгийн ОМБ-ууд 500 м3 -ээс дээш байдаг бол Завхан, Архангай, Хэнтий аймгийнх 100-300 м3 байдаг байна. ОМБ-ууд зөвшөөрөл олгосон жилд бэлтгэх модыг дунджаар 4 сарын дотор бэлтгэж байна. Ойн мэргэжлийн байгууллагууд жилд дунджаар 179,0 сая төгрөгийн борлуулалт хийж, 124,0 сая төгрөгийн зардал гарган 27.0 сая төгрөгийн ашигтай ажилладаг байна. Орлогод эзлэх цалингийн зардал 43.6 %, зардалд эзлэх цалин 62.7 % байдаг байна. Түүнчлэн ОМБ дунджаар 209.6 сая төгрөгийн нийт хөрөнгө, 29.8 сая төгрөгийн өр төлбөр, 191.6 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна.
- Ойн ангиудын өмнө тулгамдсан гол асуудал нь улс төрийн намын сонгуулийн дөрвөн жил тутамд төрийн албанд тодорхой хэмжээний халаа сэлгээ хийдэг байдал нь гол саад бэрхшээл болсон байна. СДОА-ийн даргыг мэргэжлийн бус хүмүүсээр байнга хольж, сольж байдаг нь ойн инженерүүд ажлаа эхнээс нь даргадаа тайлбарлаж, богино хугацаанд ажлаа ойлгуулж явуулах процесс нь ихээхэн хүндрэл учруулсаар байна. ОМТ-ний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээлүүдийг харьцуулж үзэхэд хамгийн их хувийг хүний нөөцийн дутагдал (22%), техник хэрэгслийн дутагдал (20%), төсөв, санхүүжилтийн дутагдал (19%), ажиллах нөхцөл (14%), мэргэшсэн боловсон хүчний хомсдол (12%), удирдлага, зохион байгуулалт (8%) хангалтгүй байх зэрэг хүчин зүйлс эзэлж байгаа бол бусад саад

бэрхшээлүүд нийт хариултын 5 орчим хувийг эзэлж байна. “Бусад” саад бэрхшээлүүд гэсэн ангилалд ойн анги/ойн байгууллагуудын дарга нар эсвэл орон нутгийн засаг захиргааны дарамт, хууль бус үйлдлийг таслан зогсоох гэхэд СДОА-ийн албан тушаалтнуудын эрх/эрх мэдэл дутмаг байх явдал, орон нутгийн засаг захиргаанаас дэмжлэг үзүүлэхгүй байх явдал, ажлын байрны тогтворгүй байдал зэрэг багтана.

- Судалгааны хүрээнд ярилцлагад хамрагдсан 36 СДОА-аас 12 СДОА-д одоогийн байдлаар хүчин төгөлдөр, батлагдсан ойн менежментийн төлөвлөгөө байхгүй байсан (Зураг 8). Үлдсэн 24 СДОА-ийн тус тус хариуцаж буй сумдын ихэнх нь ямар ч батлагдсан ОМТ-гүй, харин зөвхөн хэдхэн сумдад дөнгөж шинээр батлагдсан ОМТ бий гэж мэдэгдсэн. Одоогийн байдлаар ОМТ байхгүй гэсэн СДОА-ууд нэг бол ОМТ-г энэ жил боловсруулж байгаа, эсвэл шинээр боловсруулсан ОМТ-г аймаг, сумдын удирдлагуудад хүргүүлсэн хэдий ч батлагдахыг хүлээж байгаа гэсэн хариултыг өгсөн юм. СДОА-ууд ОМТ-г аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхнээр боловсруулдаг гэж мэдэгдсэн бөгөөд ОМТ-г өөрсдөө боловсруулж, бие даан хэрэгжүүлэх чиглэлээр илүү олон чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдахыг хүсэж байгаа талаар илэрхийлсэн.
- Санхүүгийн чадавхыг бэхжүүлэх арга замын талаар СДОА-ийн санал бодлыг асуухад дийлэнх нь төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувиар санхүүжиж, бие даасан ойн аж ахуй эрхлэх нь санхүүгийн чадавхыг сайжруулна гэж үзсэн (Зураг 18). СДОА-ууд нэг тэрбум модны аяны хүрээнд одоогийн мод үржүүлгийн газруудынхаа нөхцөл байдлыг сайжруулж, илүү олон тарьц, суулгац ургуулах шаардлагатай байгааг онцлон хэлэв. Түүнчлэн, мод үржүүлгийн газруудыг нэмэгдүүлж, МҮГ-т ажиллах боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах замаар санхүүжилтийг нэмэгдүүлэх боломжтой гэв. Гэхдээ гол асуудал нь олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг. Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойн зурвас байгуулах зэрэг үйл ажиллагаа эрхэлж, орлого олох боломжтой болсноор, СДОА-ууд олсон орлогоо өөрсдөө захиран зарцуулахыг хүсэж буйгаа илэрхийлсэн. Ойн нөөц бага учраас орлого олох боломж хомс байдгийг зарим СДОА-ууд хэлж байв. Үүнтэй холбоотойгоор ойн нөөц хомс байдаг СДОА-ууд аж ахуйн нэгжийн бүтэцтэй болсон ч ашиггүй гэж зарим нь үзсэн.
- СДОА-аас гарсан өөр нэг чухал санал бол ойн ангийн орон тоог нэмэгдүүлэх явдал байв. Гол асуудал нь Монголын ойн салбарт хийх ажил их байгаа ч боловсон хүчин дутмаг байна. Тогтвортой, үр ашигтай ажиллахын тулд мэргэшсэн, хангалттай тооны хүний нөөцтэй байх нь хамгийн чухал гэдгийг СДОА-ууд илэрхийлсэн. Мөн ярилцлагын үеэр цалингийн асуудлыг ч мөн онцлон хэлсээр байв.

5. Ойг хамгаалах, нөхөн сэргээх

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг 43 ойн анги болон аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэдэх 8 ойн алба орон нутагт хариуцан ажиллаж байна. 2020 оны байдлаар 1342 ойн нөхөрлөл 4541.9 мян.га, 131 аж ахуйн нэгж 627.4 мян.га ойн санг тус тус гэрээгээр эзэмшиж, ашиглан хамгаалж байна.[26] Орон нутагт ойн ангиуд байгуулагдаж, ойн аж ахуйн арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулах удирдлагын тогтолцоо бий болсон ч ойн ангиудыг чадавхжуулах, материаллаг баазыг бэхжүүлэх шаардлагатайг зөвлөж байна.

- 2000-2020 оны хугацаанд улсын хэмжээнд нийт жилд дунджаар 122 ой, хээрийн түймэр бүртгэгдсэн байна. Ой, хээрийн түймэрт хүний буруутай үйл ажиллагаанаас гадна хур тунадасны хэмжээ, хуурайшилт зэрэг олон хүчин зүйлээс нөлөөлж байна.

- ОтХ-ийн 26.1-д ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн

[26] Байгаль орчны төлөв байдлын тайлан 2019-2020 он, 104-р тал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, 2021 он

хөрөнгөөр хэрэгжүүлнэ гэж заасан. Судалгааны явцад ойн нөхөрлөлүүдийн 50 гаруй хувь нь бүх гишүүд ойн түймэртэй тэмцэх ажилд бүрэн оролцдог, 30 гаруй хувь тэдгээрийн гишүүдийн 60-аас доошгүй хувь нь оролцдог гэж хариулсан. Мөн гал унтраах багаж, хэрэгслийн хувьд 60 гаруй хувь нь бэлтгэл хангасан гэж хариулсан. Эндээс үзэхэд ойн нөхөрлөлүүд ой, хээрийн түймэртэй тэмцэх ажилд өөрсдийн нөөц бололцоог ашиглаж байгаа боловч багаж, хэрэгслийн хангалт, бэлтгэлийн түвшин хангалтгүй байна.

- ОтХ-д ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг ойн нөхөрлөл өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ гэж, ойн түймэртэй тэмцэхэд ямар ч урамшуулал байхгүй байгаа нь үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд нь саад тотгор үүсгэж байна. Ойн нөхөрлөл нь тухайн орон нутагт оршин сууж байгаа иргэдийн сайн дурын нэгдэл дээр бий болж ажилладаг тул санхүү, техник, хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал байдаг. Иймд хязгаарлагдмал чадамжтай этгээдэд ойн түймрээс хамгаалах чиг үүргийг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх үүрэг хүлээлгэж байгаа нь ойн нөхөрлөлүүдийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй байна.

- Ойн хөнөөлт шавжийн хөнөөлийн голомтыг хязгаарлах тэмцлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд 67.1 мян.га, 2020 онд 65.8 мян.га-д явуулсан бөгөөд энэ нь тэмцэл хийх шаардлагатай талбайн дөнгөж 35.7%-ийг хамарч байна. Гэвч энэхүү хангалтгүй байдал нь 2010 оноос хойш улам бүр багассаар 35.7 %-д хүрснийг онцгой анхаарах шаардлагатай. Хөнөөлийн голомтыг бүрэн хяналтад авч чадахгүй байгаа нь санхүүжилт дутагдалтай байгаатай холбоотой байна. Иймд ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд шаардлагатай санхүүжилтийг бүрэн олгож, хөнөөлт шавжийн голомтыг бүрэн хяналтыг бүрэн хяналтад авахыг зөвлөж байна.

- Хууль бусаар бэлтгэгдэж хураагдсан мод 2007 онд 12941.7 м.куб байсан бол 2021 оны байдлаар 361.7 м.куб болж, бүртгэгдсэн хэрэг, зөрчлийн тоос 2007 онд 809 байсан бол 2021 онд 460 болж тус тус буурсан байна. Дурдсан 2007 онд тоног төхөөрөмж, моторт болон тавцантай хөрөө 60 ширхгийг улсын орлого болгож байсан бол 2021 оны байдлаар 3 болж буурч хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд тодорхой ахиц гарсан байна.

- Улсын хэмжээнд 2019 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 2392,5 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 4683,5 га талбайд, ойн зурас байгуулах ажлыг 1878,1 га талбайд хийж, ойжуулах, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 8954.1 га талбайд хийсэн бол 2020 онд улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 3088,7 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 582 га талбайд, ойн зурвас байгуулах ажлыг 371.5 га талбайд хийж, ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг нийт 4042,2 га талбайд хийжээ. Жил бүр явуулдаг ой зохион байгуулалтын судалгааны үр дүнгээс харахад 1990, 2000 оны эхэн үеийн их түймэрт нэрвэгдсэн ойгоос 1.0 сая.га орчим нь байгалийн аясаараа сэргэн ургаж байгаа бөгөөд дахиж түймэр, хөнөөлт шавжид өртүүлэхгүй байх, гэрэлжүүлэх, тохируулах хэлбэрийн арчилгааны огтлолтыг явуулж, өсөлтийг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлбэл ойгоор бүрхэгдсэн талбайд шилжих бүрэн боломжтой байна. Харин сэргэн ургалт хангалтгүй байгаа 462.5 мян.га талбайд тарьц, суулгацаар зориудаар ойжуулах, өсвөр модыг хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай байгаа боловч улсын болон орон нутгийн төсөв хүрэлцэхгүй байна.
  Мөн түүнчлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мод тарих үндэсний өдөр”-т иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд идэвхтэй оролцдог боловч тарьсан мод, сөөгөнд байнгын арчилгаа, хамгаалалт хийгддэггүйгээс мод, сөөгний ургалт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай.
- Ойн тухай хуулийн 3.1.6-д “ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт

бичгийг хэлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл шат шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж ойн менежментийн төлөвлөгөөтэй байхаар зохицуулсан боловч ОтХ-д хуульд шат шатны ойн менежментийн төлөвлөгөө хоорондоо хэрхэн уялдах нь тодорхой бус байгаагаас ойн менежментийн төлөвлөгөөг цогц байдлаар хэрэгжүүлэх боломжгүй байна.

- Улсын ойн менежментийн төлөвлөгөө нь түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төлөвлөх, батлах, зарцуулахтай уялдахгүй байна. Учир нь улсын ойн менежментийн төлөвлөгөөний төслийг Ойн агентлаг боловсруулж[27], яам баталж, ойн менежментийн төлөвлөгөөг яам хэрэгжүүлж[28] байгаа боловч түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, санхүүжүүлэх чиг үүргийг Ойн агентлагт[29] олгосон байна. Өөрөөр хэлбэл Ойн агентлаг улсын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах чиг үүрэг нь Төсвийн тухай хууль болон орон нутгийн өөрөө удирдах ёсны чиг үүрэгтэй зөрчилдөж байна.

  Мөн түүнчлэн ОтХ-д аймаг, нийслэл ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлах болон хэрэгжилтийг хангах этгээд нь тодорхой бус байгаагаас аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. ОтХ-ийн 14.3.2-т зааснаар Ойн агентлагт аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах бүрэн олгогдсон боловч ОтХ-ийн 17.1-т Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхэд, 17.2-т Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, шаардагдах төсвийг батлах асуудал огт тусгагдаагүй байна. Харин тус хуулийн 17.1.1-т Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих эрхтэй гэж, мөн хуулийн 17.2.2-т Аймаг, нийслэлийн Засаг дарга ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах бүрэн эрхтэй гэж тус тус заасан. Эндээс үзэхэд аймаг, нийслэл ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах төсвийг батлах, хэрэгжүүлэх этгээд нь тодорхой бус байна. Энэ байдал сумын түвшинд мөн адил давтагдаж байна.

  Иймд ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, төсөв батлах, зарцуулах, хэрэгжилтийг хянах этгээдийг Төсвийн тухай хууль, орон нутгийн өөрөө удирдах ёсны зарчим, үр ашигтай, хэрэгжихүйц байдлаар өөрчлөхийг зөвлөж байна.

6. Ойг ашиглах

- Ойн нөөцийг тогтвортой ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгамдаж байна. Жилд бэлтгэх модны квот тогтоох үйл явц нь дээд хэсэгтээ салбар хариуцсан мэргэжлийн яамны оролцоотой байх бол орон нутгийн түвшинд захиргааны болон улс төрийн институцийн асар их оролцоотой улс төрийн шинжтэй шийдвэр гаргах үйл явц болж хувирсан байна. Ойн нөөц бэлтгэх хэмжээ тогтооход дээр дурдсанаар улс төр, төрийн захиргаа, сум орон нутгийн зэрэг олон тооны оролцогч талуудтай байхын зэрэгцээ квот тогтоохдоо юуг үндэслэх буюу ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл болсон ойн менежментийн төлөвлөгөөг огт тусгаагүй байгааг өөрчилж, тухайн жилд бэлтгэх модны нөөцийн хэмжээг зөвхөн ойн

[27] ОтХ-ийн 14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих,

[28] ОтХ-ийн 13.1.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих

[29] ОтХ-ийн14.3.2.улсын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих

менежментийн төлөвлөгөөг харгалзан тогтоодог болох нь зүйтэй. Энэ тохиолдолд улс төрийн болон бусад ашиг сонирхлын шинжтэй шийдвэр гаргах орон зай хумигдаж, модыг зөвхөн нөөцийн хэмжээ, ашиглалтын горим зэрэг хүнээс хамааралгүй хүчин зүйлсэд тулгуурлан ашигладаг болох суурь тавигдана.

- Ойн дагалт баялгийг мөн зохистой, тогтвортой ашиглах эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдсан. Хамгийн нийтлэг ашигладаг ойн дагалт баялаг нь сибирь хуш модны үр буюу самар. Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацын жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө гэж ОтХ-д заасан боловч ургацыг хэрхэн тодорхойлох талаар өөрөөр заасан зүйл хуульд тусгагдаагүй. Ойн дагалт баялгийн нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, ойн дагалт баялаг байгалийн жамаараа нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний тулд ойн дагалт баялгийн нөөцийг биологийн буюу байгаль дээр байх бодит нөөц, ашиглах нөөц буюу тухайн жилд түүж бэлтгэх хэмжээг тооцдог аргачлал, шалгуур үзүүлэлт гаргах, эдгээрийн дагуу тодорхойлж тогтоосон хэмжээнд дагалт баялгийн нөөцийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.
- Зөвшөөрлийн тухай хуульд ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар олгоход заавал дуудлага худалдаа зохион байгуулахаар, дуудлага худалдааны журмыг тухайн салбарын хуулиар зохицуулахаар тусгасан. Иймд ОтХ-д ойн дагалт баялгийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглуулах эрхийн бичгийг олгох зохицуулалтыг ялгамжтай тусгах, үйлдвэрлэлийн зориулалтаар эрхийн бичиг олгох дуудлага худалдаа явуулах журмыг хуульчилж тогтоох шаардлагатай.
- Ойн дагалт баялгийг ашиглахдаа мод болон ойн нөөцийг гэмтээх арга хэрэгсэл ашиглах нь нийтлэг ажиглагдаж байна. Өнөөгийн байдлаар хэдий ч хэмжээний хушин ой ийм зохисгүй арга технологи ашигласны улмаас гэмтсэн, устсан талаарх тодорхой тоо баримт, судалгаа тооцоо байхгүй боловч үүнийг хуульд тусгайлан зааж хориглох гарцаагүй шаардлага үүсэж буй юм.

Иймд Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дээрх судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Ойн тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т заасны дагуу Ойн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулж, батлуулах нь зүйтэй байна.

-----oOo------